
ТАВ. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ БУСАД ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР
ТОМЬЁОНЫ СУДАЛГАА

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur)
----------------	--

Судалгааны багийн бусад гишүүд:

С.Сүхбаатар	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (LL.D)
Х.Буянбат	Эрдэм шинжилгээний ажилтан
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Энэхүү судалгааг ХЗҮХ-ийн 2022 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.14-т заасны дагуу хийсэн болно.

Судалгааг гүйцэтгэж ХЗДХЯ-нд хүргүүлсэн огноо: 2022.06.10.

АГУУЛГА

УДИРТГАЛ	261
I. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА	
1. “Гойд ашиг шимт мал” гэх нэр томьёоны тухайд	262
2. “Тусгай хамгаалалттай газар” гэх нэр томьёоны тухайд	264
3. “Ашигт малтмал” гэх нэр томьёоны тухайд	265
4. “Ашигт малтмал ашиглах” гэх нэр томьёоны тухайд	267
5. “Ашигт малтмалын эрэл хайгуул” гэх нэр томьёоны тухайд	269
6. “Түүхий эд” гэх нэр томьёоны тухайд	271
7. “Байгалийн тэнцэл” гэх нэр томьёоны тухайд	274
II. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА	
1. “Төрийн нууц” гэх нэр томьёоны тухайд	277
2. “Садар самуун” гэх нэр томьёоны тухайд	278
III. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА	
1. “Валют, Валютын ханш” гэх нэр томьёоны тухайд	279
IV. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА	
1. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэх нэр томьёоны тухайд	281
2. “Халдварт өвчин” гэх нэр томьёоны тухайд	282
3. “Ураг зулбасан” гэх нэр томьёоны тухайд	283
4. “Хууль бусаар үр хөндөх” гэх нэр томьёоны тухайд	285
5. “Хөгжлийн бэрхшээлтэй” гэх нэр томьёоны тухайд	288
6. “Сэтгэл засал” гэх нэр томьёоны тухайд	292
7. “Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн” гэх нэр томьёоны тухайд	237
8. “Донтох зуршлын эсрэг эмчилгээ” гэх нэр томьёоны тухайд	301
V. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ХҮН АМ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА	
1. “Орон байр” гэх нэр томьёоны тухайд	304
2. “Асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэх нэр томьёоны тухайд	305
3. “Харьяалалгүй хүн” гэх нэр томьёоны тухайд	308
VI. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА	
1. “Хор хөнөөлт программ хангамж” гэх нэр томьёоны тухайд	310
2. “Галт зэвсэг, галт хэрэгсэл” гэх нэр томьёоны тухайд	311
НОМЗҮЙ	312

УДИРТГАЛ

Судалгааны зорилт: Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих, хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх, жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх зэрэг асуудлыг хуульчилсан байдаг.

Энэхүү зохицуулалт нь хууль зүйн техникийн ерөнхий дүрмийн нэг болох эрх зүйн логик зүй тогтлыг хангах дүрмийн нэр томьёог нэгдмэл байдлаар ойлгох агуулгад үндэслэдэг. Нэр томьёог нэгдмэл байдлаар ойлгох нь нэг баримт бичигт нэр томьёог өөр өөр утгаар зөрчилдүүлэн хэрэглэхгүй байх санааг агуулдаг бөгөөд хэрэв энэ дүрмийг зөрчсөн бол уг хууль зүйн баримт бичиг нь хэрэглэгчдийг төөрөгдүүлдэг.

2021 онд Хууль зүйн үндэсний хүрээлэн “Эрүүгийн хууль дахь бусад шинжлэх ухааны нэр томьёоны судалгаа”-г хийж гүйцэтгэсэн ба тухайн судалгааг хийх явцад Эрүүгийн хууль дахь бусад шинжлэх ухааны нэр томьёог шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлах, практикт нэг мөр хэрэглэх, ойлгох шаардлагатай байгаа нь ажиглагдсан. Тэрхүү судалгааны хүрээнд Эрүүгийн хууль дахь бусад шинжлэх ухааны 14 нэр томьёог судалж дүгнэлт, саналыг боловсруулсан. Харин энэхүү судалгаагаар тус 14 нэр томьёог өргөжүүлэн судлах шаардлагатай гэж үзсэн юм.

Тийм учраас Эрүүгийн хуулийн ерөнхий болон тусгай ангийн хүрээнд бусад шинжлэх ухааны түүвэрлэн авсан нэр томьёог судалж шинжлэх ухааны үндэслэлтэй, практик ач холбогдолтой нэр томьёоны тайлбарыг бий болгоход оршино.

Судалгааны хүрээ: Судалгааг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн бусад шинжлэх ухааны сонгогдсон нэр томьёоны хүрээнд гүйцэтгэнэ.

Судалгааны арга зүй: Дээрх судалгааны ажлыг гүйцэтгэхдээ үгийн үндсийг тодорхой үндэслэлтэй гаргахын тулд шинжлэх ухааны гременивтик арга, түүхэн талаас нь түүхчлэх арга, тухайн үгийн агуулгыг илүү тодорхой болгохоор харьцуулалтын арга, холбогдох зүйл заалт, үгийн утга агуулгыг ойлгох үүднээс утга зүйн аргуудыг тус тус хэрэглэнэ.

Хүлээгдэж буй үр дүн: Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь эрүүгийн хуулийн түүхэн уламжлал, хөгжлийн чиг хандлага, гэмт хэрэг, ялын тухай, эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал зэрэг өргөн ойлголтыг өөртөө багтаахын зэрэгцээ эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, криминологи, криминалистик, эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй, иргэн, хөдөлмөр, эдийн засгийн гэх мэт салбар эрх зүйн болон бусад шинжлэх ухаантай нягт хөгжиж ирсэн юм. Тиймээс бусад шинжлэх ухааны нэр томьёог судлах нь Эрүүгийн хуулийн холбогдолтой зүйл, заалтуудыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх үндэс болно.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга буюу одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн бусад шинжлэх ухааны нэр томьёо агуулагдсан зохицуулалтыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн хуулийн бусад шинжлэх ухааны нэр томьёог судлах хэрэгцээ, шаардлага бий болоод байна.

I. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА

1.1. “Гойд ашиг шимт мал” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт тусгагдсан байна.

Олон улсын тодорхойлолтод үүнийг маш үр дүнтэй байхаар бүтээгдсэн мах, сүү болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор өсгөсөн үхэр болон бусад фермийн амьтад¹ гэж тодорхойлдог байна.

2017 оны Малын генетик нөөцийн тухай² хуулийн 4.1.9-т “гойд ашиг шимт мал” гэж үүлдэр, омгийн мал сүргээс үржил, ашиг шимийн нэг буюу хэд хэдэн чанараар онцлог давуу болох нь баталгаажсан малыг хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг ба 4.1.1-т “мал” гэдгийг уламжлагдан маллаж ирсэн таван хошуу мал гэж тайлбарласан. “гойд ашиг шимт мал”-ыг хэрхэн шалгаруулах талаар тус хуулийн 15.4-т “Малын үндэсний генийн санд үржүүлгийн бүтээгдэхүүн байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих болон гойд ашиг шимт мал шалгаруулах журам, энэ хуулийн 15.1-д заасан үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны бүтэц, орон тоог малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж зааснаар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд тухайн журмыг батлахаар хуульчлагджээ.

2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А-346 тоот тушаалын хавсралтаар тухайн хуулийн зохицуулалтын дагуу “Гойд ашиг шимт мал шалгаруулах журам”-ыг баталсан байна. Энэхүү журмаар дараах онцлог зохицуулалт хийжээ.

- Гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагааг сум, дүүрэгт Хөдөө аж ахуйн тасаг, аймаг, нийслэлд Хүнс, хөдөө аж ахуйн газар, улсын хэмжээнд Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах
- Гойд ашиг шимт малыг шалгаруулах ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл, мэргэжилтнийг оролцуулан сум, аймаг, нийслэлд тухайн шатны Засаг дарга, улсад Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд) тус тус байгуулах
- Ноос, ноолуурын чиглэлийн ашиг шимт малын шалгаруулалтыг хавар, бусад ашиг шимийн чиглэлийн мал, амьтны шалгаруулалтыг намар зохион байгуулах
- Шалгарсан гойд ашиг шимт шилмэл малыг улсын үржлийн дэвтэрт бүртгэж, гэрчилгээ олгох
- Гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд хурдны чиглэлийн адуунаас бусад мал, тэжээвэр амьтныг оролцуулах
- Сум, дүүрэгт шалгарсан гойд ашиг шимт мал, амьтан тэдгээрийн төл нь аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлд шалгарсан малыг улс, бүсийн гойд

1 Heather Bateman, Steve Curtis, Katy McAdam, “*Dictionary of Agriculture third edition*”, A & C Black Publishers Ltd, 2006.

2 Малын генетик нөөцийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №03 (2018)

- ашиг шимт малыг шалгаруулах үзэсгэлэн худалдаанд оролцуулах
- Ашиг шимийн үзүүлэлт нь “Мал ангилах заавар”-т заасан цөм сүргийн малд тавих шаардлагаас илүү үзүүлэлттэй байх
 - Адууны төрөлд 12, тэмээ 6, үхэр 18, хонь 25, ямаа 10, сарлаг 5, гахай 7, шувуу, жижиг амьтан 3 тус тус гойд ашиг шимт малаар шалгаруулах
 - Амьдын жин, ноос, ноолуурын гарцаар тэмээг 6, үхрийг 5, ямааг 4, гахайг 2 настайд нь, сүүний гарцаар үнээг 6, ингийг 8 настайд нь тус тус улсад шалгаруулах

2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар дээрх заалтууд нэмэгдсэн. Улсын их хурлын гишүүн Х.Болорчулууны 2020 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалд “Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлан гаргасан Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.7-д “цөм сүрэг”, 4.1.9-д “гойд ашиг шимт мал”-ыг тусгайлан заасан бөгөөд дээрх малын генетик нөөц, удам зүйн үнэлгээ, хянан магадлагаа хийх, баталгаажуулах асуудлыг зохицуулсан. Мал, мах, малын гаралтай түүхий эдийн үнэ ханш зах зээлд тогтмол хэлбэлзэж байдаг ба цөм сүрэг, гойд ашиг шимт малын эдийн засгийн үнэлгээ нь харилцан адилгүй тогтоогддог болно.” гэж тухайн зохицуулалтын үзэл санааг тусгасан байдаг. Үүнээс гадна тухайн үед Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг ажлын хэсгийн гишүүн Х.Нямбаатар “Мөн хурдан удмын адуу зэрэг өндөр ашиг шимтэй малыг хулгайлсан бол хүндрүүлэх нөхцөлд тооцогдоно.”³ гэх санааг илэрхийлж байжээ.

Гэтэл гойд ашиг шимт мал шалгаруулах журмын 3.1-д “Гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд хурдны чиглэлийн адуунаас бусад мал, тэжээвэр амьтныг оролцуулах бөгөөд...” гэж зааснаас үзвэл дээрх нэр бүхий Улсын Их Хурлын гишүүний илэрхийлсэн санаа нь гойд ашиг шимт малд хамаарахааргүй зохицуулагдсан байна.

Улсын их хурлын гишүүн Х.Болорчулууны 2020 оны Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалд цөм сүрэг болон гойд ашиг шимт малыг эдийн засгийн үнэлгээ нь харилцан адилгүй тогтоогддог гэж тодорхойлсон хэдий ч цөм сүргийг Эрүүгийн хуулийн 17.12 буюу мал хулгайлах гэмт хэрэгт хуульчлаагүй. Цөм сүрэг гэдэг нь 2017 оны 12 сарын 14-ний “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн 4.1.7-д зааснаар тухайн үүлдэр, омгоос ашиг шимийн хэмжээ, чанараар давуу хэсгийг сонгон үржүүлж байгаа сүрэг малыг хэлдэг. Хуулийн болон журмын тодорхойлолтоор цөм сүрэг нь гойд ашиг шимт малнаас бага ашиг шимт чанарыг агуулах нь харагдаж байгаа бөгөөд тооны хувьд шалгаруулж, баталгаажуулах үйл ажиллагаанд оролцохгүй учир их байхаар харагдаж байна. Гэхдээ ашиг шимт байдлын хувьд хоёулаа энгийн мал буюу үржлийн болон хэрэгцээний малаас дээгүүр байна. Тиймээс тухайн цөм сүргийн ангиллын малыг хулгайлж үйлдсэн байхыг Эрүүгийн хуульд оруулах үзэл баримтлал байгаа хэдий ч хуульд дээрх зохицуулалтыг тусгаагүй учир тухайн зохицуулалтыг тусгавал үүлдэр, омгоос ашиг шимийн хэмжээ, чанараар давуу малыг хулгайлсан тохиолдолд гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр зүйлчилж тухайн төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд үр нөлөөтэй байж болох юм.

3 Х.Нямбаатар, “Хурдан удмын адуу хулгайлсан бол хүндрүүлэх нөхцөл болно”, (сурв. Т.Сайхан), 2020.01.10, Холбоос: <https://www.polit.mn/a/77974>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.10.

Эрүүгийн хуулийн 17.12.2.6 буюу мал хулгайлах гэмт хэргийг гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдэх үйлдлийн тухайд гойд ашиг шимт малыг шалгаруулах үйл ажиллагаа тогтмол хийгддэггүй. Үүний улмаас улмаас гойд ашиг шимт малын нийт малын дунд эзлэх хувийн жин бага байх, тухайн асуудлын улмаас зохицуулалт нь хуулийн үзэл баримтлалд нийцээгүй байх буюу мөн цөм сүргийг тухайн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлаагүй байх, хурдны чиглэлийн адуу гойд ашиг шимт малд хамаарагдахгүй байх гэх мэт хэрэгжилтийн үр дагавартай холбоотой асуудлууд бий болоод байна.

Түүнчлэн практикт ажиллаж буй хууль сахиулагч буюу цагдаагийн алба хаагчдын хувьд тухайн эрх зүйн зохицуулалтыг хэрэглэхдээ нэг утгаар ойлгодоггүй буюу гойд ашиг шимт мал шалгаруулах журмыг мэдэхгүй байгаагаас гойд ашиг шимт мал бусад малаас юугаараа онцлог давуу талтай болохыг нарийн тодорхойлохгүй байх гэх мэт дутагдлуудыг бий болгож байна.

1.2. “Тусгай хамгаалалттай газар” гэх нэр томъёоны тухайд.

Тус нэр томъёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 24.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-т тус тус тусгагдсан байна.

Тусгай хамгаалалттай байгалийн бүс нутаг нь байгаль хамгаалах, шинжлэх ухаан, соёл, гоо зүй, амралт, эрүүл мэндийн онцгой ач холбогдолтой байгалийн цогцолбор, объект байрладаг газар, усны гадаргуу, тэдгээрийн дээгүүр агаарын орон зай юм. Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр эдгээр нутаг дэвсгэрийг эдийн засгийн ашиглалтаас бүрэн буюу хэсэгчлэн хасч, тусгай хамгаалалтын дэглэм тогтоодог. Тусгай хамгаалалттай байгалийн газар нутаг нь үндэсний өвийн объектод хамаарна⁴.

1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар “Тусгай хамгаалалттай газар нутгийг”-ыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг хэмээн ялган үзсэн.

Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

1993 онд Монгол Улс Биологийн олон янз байдлыг хамгаалах конвенцод нэгдэн орсноор өөрийн орны болон бүс нутгийн байгаль экологийн тэнцлийг хангахад онцгой үүрэгтэй газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах асуудалд өндөр ач холбогдол өгөх болсон.⁵ Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 1. дархан цаазат газар 2. байгалийн цогцолбор газар, 3.байгалийн нөөц газар, 4. дурсгалт газар хэмээн 4 ангилсан.⁶ Манай улсын хувьд 102 байршилд нийт 107 “Улсын тусгай хамгаалалттай газар нутаг” байна.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлд “Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг

4 Холбоос: <https://wwf.ru/en/regions/the-caucasus/development-of-system-of-especially-protected-natural-territories/>, Сүүлд үзсэн огноо: 2021.12.14.

5 Тусгай хамгаалалттай газар, Холбоос: <http://mpa.gov.mn/news/885>, Сүүлд үзсэн огноо: 2021.12.14.

6 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн (1994) 3 дугаар зүйл, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/479>, Сүүлд үзсэн огноо: 2021.12.14.

орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно” гэж хуульчилсан. Уг хуулийн дагуу 1994 оноос эхлэн 2021 оныг хүртэлх хугацаанд 2798 газрыг орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг болгосон. Үүнээс 974 нь Аймаг, нийслэлийн тусгай хамгаалалттай газар нутаг бол үлдсэн 1824 сум дүүргийн тусгай хамгаалалттай газар нутаг байна.⁷

Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-ийн 4.6.2 дахь хэсэгт “тусгай хамгаалалттай газар нутагт хийсэн судалгааны үр дүн, баримт, мэдээллийг нэгдсэн санд төвлөрүүлэх” гэж тусгай хамгаалалттай газрыг мэдээллийн санд оруулах харилцааг зохицуулсан. Үүний дагуу 1997 оны “Геодези, зураг зүйн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан /цаашид “нэгдсэн сан” гэх/ нь геодезийн сүлжээний, байр зүйн зургийн, агаар, сансрын зургийн, газар зүйн нэрийн болон кадастрын тухай мэдээлэл, тэдгээртэй холбогдох бусад тоон мэдээллээс бүрдэнэ. Нэгдсэн сан нь төрийн өмч байна.” гэж зааснаар өөрийн цахим хаяг болох <https://egazar.gov.mn/api/landuse/nav> -т газрын болон кадастрын зургийг оруулдаг байна. Мөн Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаануудын цахим хаяг болох <http://mpa.gov.mn/pas/list> -т тусгай хамгаалалттай газар нутгийг төрлөөр нь харуулсан мэдээлэл байна.

1.3. “Ашигт малтмал” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт тусгагдсан байна.

Монгол хэлний их тайлбар тольд ашигт малтмал гэдгийг газрын хэвлийд үүсэн бий болсон байгалийн байдлаараа байгаа эрдэс бодисын хуримтлал⁸ гэж тайлбарласан.

Хууль зүйн талаас авч үзвэл ашигт малтмал гэх нэр томьёог 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлал” гэж тодорхойлсон байна. Тус хуулийн 6 дугаар зүйлд ашигт малтмалын ордын ангиллын талаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, ердийн ашигт малтмалын орд гэсэн ангилалд хуваахаар зохицуулсан. Мөн тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-т ашигт малтмалын төлбөр төлөгчийн төлбөр төлөх нэмэгдүүлсэн хувийг хуульчлахдаа ашигт малтмалын төлбөр ногдох ашигт малтмалын жагсаалтыг гаргасан байна. Үүнд зэс, алт, цайр, молибдени, төмөр, гянтболд, хайлуур жонш, жоншны баяжмал (флотацийн баяжмал), цагаан тугалга, хар тугалга, боловсруулаагүй нүүрс, баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн), эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн), мөнгө, магнезит, хөнгөн цагаан, газрын ховор элемент, фосфорит, цеолит, судлын кварц, чулуун давс, мөсөн шүү, гөлтгөнө гэх ашигт малтмалууд хамаарч байна.

7 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, Холбоос: <https://eic.mn/spalocal/index.php>, Сүүлд үзсэн огноо: 2021.12.14.

8 Монгол хэлний их тайлбар толь, Холбоос: <https://mongoltoli.mn/dictionary/detail/8736>, Сүүлд үзсэн огноо: 2022.03.17.

Хууль зүйн толь бичигт ашигт малтмал гэдгийг газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа⁹ гэж тодорхойлсон байна. Мөн олон улсын эрх зүйн толь бичигт ашигт малтмал гэдгийг нэгдүгээрт тодорхой физик шинж чанар болон химийн найрлага нь түүний үнэ цэнийг тодорхойлдог байгалийн органик бус бодис, хоёрдугаарт хайгуул хийх, ашиглах, олборлох зориулалттай арилжааны болон ашигтай шинж чанартай газрын хэвлийн материал, гуравдугаарт хууль болон шүүхийн жишгээр ашигт малтмал гэж тодорхойлсон аливаа байгалийн материал¹⁰ гэж тус тус тодорхойлсон. Органик бус гэдэг нь амьд организмээс үүсээгүй, органик аргаар үүссэн нүүрстөрөгч агуулаагүй бодис¹¹ юм.

Геологи, минералогийн шинжлэх ухаанд ашигт малтмалын төрөл зүйл гэдэг нь ерөнхийд нь хэлбэл, байгалийн цэвэр хэлбэрээр бий болсон, нэлээд тодорхой химийн найрлагатай, тодорхой болор бүтэцтэй хатуу химийн нэгдэл юм¹² гэж тодорхойлсон байна. Геологийн шинжлэх ухаан гэдэг нь дэлхийн гадаргуу дээрх хатуу материалуудыг судалдаг шинжлэх ухаан бөгөөд энэ нь дотроо минералог, геодези, стратиграфийн шинжлэх ухааныг хамааруулдаг¹³ бол минералогийн шинжлэх ухаан нь зөвхөн ашигт малтмалын талаар судалдаг шинжлэх ухаан байна. «Ашигт малтмал» гэсэн тодорхойлолт улам бүрхэг болохын хэрээр бусад шинжлэх ухаантай улам бүр давхцаж минералогийн хил хязгаар нээгдэж байгаа¹⁴. Минералогийн шинжлэх ухааны хувьд ашигт малтмалыг тодорхой болсон химийн найрлагатай бөгөөд энэ нь түүнийг ангилж нөхцөл болдог материал юм гэж тодорхойлсон ба өнөөдрийн мэдэгдэж буйгаар нийт 5000 гаруй ашигт малтмал энгийн элементийн, сульфид болон сульфосалтын, халогенидын, оксидын, карбонатын, нитратын, боратын, иодын гэх мэт 14 химийн бүлэгт хуваагддаг гэж үздэг байна¹⁵. Тус тодорхойлолт нь ашигт малтмалын талаар хэт нарийвчилсан тодорхойлолтыг минералогийн шинжлэх ухааны зүгээс өгсөн байна. АНУ-ын “The Hudson Institute of Mineralogy” гэх байгууллагын зүгээс Mindat.org¹⁶-г дараах байдлаар ашигт малтмалыг тайлбарласан байна.

Ашигт малтмал нь дараах шинжийг агуулдаг химийн элемент эсвэл нэгдэл юм.
Үүнд:

1. Их, бага, тогтмол найрлагатай;

9 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (УБ, 2007), 52 дахь тал.

10 Bryan A. Garner, “*Black’s law dictionary: Eight edition*”, (Thomson West, 2004), p.3150.

11 *What Does Inorganic Matter Mean?*, Холбоос: <https://www.corrosionpedia.com/definition/678/inorganic-matter#:~:text=Inorganic%20matter%20is%20matter%20which,they%20are%20not%3A%20organic%20compounds>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

12 John P. Rafferty, ed. (2011): *Minerals; p. 1. In the series Geology: Landforms, Minerals, and Rocks. Rosen Publishing Group.*

13 Britannica, T. Editors of Encyclopaedia, “*geology*” *Encyclopedia Britannica*, October 25, 2018, Холбоос: <https://www.britannica.com/science/geology>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

14 Bulakh, Hans-Rudolf Wenk, Andrey, *Minerals Their Constitution and Origin*, (Cambridge university press, 2016), p.3, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

15 Bulakh, Hans-Rudolf Wenk, Andrey, *Minerals Their Constitution and Origin*, (Cambridge university press, 2016), p.42, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

16 Ашигт малтмал, тэдгээрийн нутаг дэвсгэр, орд, уурхайн асуудлаар дэлхийн тэргүүлэгч байгууллагын цахим хуудас буюу мэдээллийн бааз юм. Энэхүү төслийн хүрээнд дэлхийн мэргэшсэн 50 эксперт буюу мэргэжилтэнүүд ажилладаг.

2. Болор бүтэц дэх ион ба молекулуудын дараалсан гурван хэмжээст массив бүхий хатуу биет;
3. Байгалийн геологийн процессоор хүний болон бусад биологийн оролцоогүйгээр үүсдэг;
4. Хоёр ба түүнээс дээш холимог бодисуудын хольц биш.¹⁷

Mindat.org гэх мэдээллийн сан нь ашигт малтмалыг бүртгэхдээ Олон улсын минералогийн холбооны бүртгэсэн 5779 зүйлийн ашигт малтмалыг бүртгэж тоон үзүүлэлтийг гаргадаг байна.

Олон улсын минералогийн холбоо нь 1958 онд байгуулагдсан одоогоор 38 улс, орны минералогийн холбоог өөртөө нэгтгэсэн байгууллага юм. Тус холбоо нь 2022 оны 3 дугаар сарын байдлаар нийт 5794 зүйлийн ашигт малтмалыг бүртгээд байна¹⁸.

Дүгнэвэл ашигт малтмал гэх нэр томьёо нь Эрүүгийн хуульд тусгагдсан байгалийн шинжлэх ухааны буюу геологи, минералогийн шинжлэх ухааны нэр томьёо бөгөөд Монгол Улс үүнийг мөн дотоодын хууль тогтоомжид зохицуулсан байна. Монгол Улсын “Ашигт малтмалын тухай хууль”-д заасан 24 төрлийн ашигт малтмалаас дэлгэрэнгүйгээр буюу 5794 зүйлийн ашигт малтмалыг минералогийн шинжлэх ухаанд тодорхойлсон байна. Тиймээс зөвхөн үндэсний хууль, тогтоомжоор хязгаарлагдахгүйгээр уг нэр томьёог ойлгох нь зүйтэй.

1.4. “Ашигт малтмал ашиглах” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт тусгагдсан байна.

2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-т “ашигт малтмал ашиглах” гэдгийг газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа гэж зохицуулсан. Хууль зүйн нэр томьёоны хувьд мөн дээрх байдлаар¹⁹ тайлбарлажээ.

“Ашигт малтмалын тухай хууль”-д 10 дугаар зүйлийн 10.1.7-т зааснаар төрийн захиргааны төв байгууллага нь “ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам батлах, бүтээгдэхүүний стандартыг боловсруулж батлуулах” бүрэн эрхийг эдэлдэг. Үүний дагуу Монгол Улсын уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 тушаалаар “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам” батлагдсан ба тус журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах зорилгоор явуулж буй геологи, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг зохицуулахаар заажээ. Тус журмын 1.4-т “ашиглалтын ажлыг ашиглалтын өрөмдлөг, тэсэлгээ, олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт гэсэн дэс дарааллаар гүйцэтгэнэ.” гэж ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг тодорхойлсон байна. Мөн үүнээс гадна тус журмын

17 *What is a mineral?* By Donald Peck, Холбоос: https://www.mindat.org/a/what_is_a_mineral, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

18 *The New IMA List of Minerals – A Work in Progress* – Updated: March 2022, Холбоос: http://cnmnc.main.jp/IMA_Master_List_%282022-03%29.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.03.15.

19 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (УБ, 2007), 52 дахь тал.

наймдугаар бүлэгт ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд тавигдах шаардлага, есдүгээр бүлэгт ашигт малтмал ашиглалтын үед тавигдах шаардлагуудыг тус тус хуульчилсан.

Ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавьсан байна.

Үүнд:

- Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан байна.
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөцөд тулгуурлан уул уурхайн (ашигт малтмал олборлох, баяжуулах) төслийг хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан байна.
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийлгэж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан байна.
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газар, ус, цахилгаан зэрэг дэд бүтэцтэй холбоотой зөвшөөрлүүдийг холбогдох байгууллагуудаас авч, шаардлагатай тохиолдолд гэрээ хийж, холбогдох төлбөрийг төлсөн байна.
- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсаны дагуу уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийг барьж байгуулан эрх бүхий байгууллагаас томилогдсон техникийн комиссоор шалгуулан акт үйлдүүлж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисст хүлээлгэн өгч уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ажиллуулж эхэлнэ.
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дотоод, гадаадын хөрөнгийн биржид хувьцаа гаргасан тохиолдолд аудит хийлгэсэн санхүүгийн тайлангаа жил бүр өөрийн компани цахим хуудсанд монгол хэл дээр байршуулна.

Харин ашигт малтмал ашиглалтын үед дараах шаардлагууд тавигдаж байна.

Үүнд:

- Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан аюулгүй ажиллагааны дүрмүүдийн шаардлагад нийцүүлэн явуулна.
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байрыг “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д зааснаар тоноглон тэсэлгээний ажлыг уг дүрмийн дагуу явуулна.
- Баяжуулах үйлдвэрийн металл авалт, хаягдлын сангийн саармагжуулалт, далд уурхайн агааржуулалт, агаарын бохирдолт зэргийг хэмжиж мэргэжлийн байгууллагаар хянуулж акт, баримт бүрдүүлж ажиллана.
- Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд нь Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дах хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлсэн байна.
- Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.12, 11.1, 48.6, 48.7, 48.11-д заасны дагуу ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон

баяжуулах, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нь уурхай болон уулын баяжуулах, боловсруулах үйлдвэрийн дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд, уулын ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийн тайланг тухайн ордыг ашиглах болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл дээр тулгуурлан хийж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах заавар”-ын дагуу хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.

- Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, жилийн тайланд уулын ажлын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн холбогдох график зураг, материалыг хавсаргана.
- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нь тухайн жилд тусгай зөвшөөрлийн талбайд болон үйлдвэрийн газарт үйл ажиллагаа явуулаагүй бол энэ тухай үндэслэл, тайлбарыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.
- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн тэдгээрийг аюулгүй ажиллагааны сургалтад хамруулж улмаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авч ажиллана.
- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад хамрагдсан байдал, ажлын байрны нөхцөл, ажлын тусгай хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэл дээр гарсан осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл болон аюул учирч болзошгүй байсан тохиолдлын талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүр хүргүүлнэ.
- Ус, агаар, хөрсний бохирдлыг тогтмол хянаж, мэдээллийн санг бүрдүүлж, шаардлагатай үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж ажиллана.
- Ашиглалтын блокийг нээх, хаахдаа акт үйлдэж хайгуулын ажлаар тогтоосон нөөцийн хэмжээ батлагдсан, дутсан, үлдсэн, илүү гарсан эсэх, тэдгээрийн шалтгааны талаар тодорхой тайлбар бичиж нөөцийн баланс гаргах үедээ төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

1.5. “Ашигт малтмалын эрэл хайгуул” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт тусгагдсан байна.

2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-т “ашигт малтмал хайх” гэдгийг эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг ойлгохоор байна. Харин тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-т “ашигт малтмал эрэх” гэдгийг ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд эрдсийн хуримтлал байгаа эсэхийг тогтоох зорилгоор

хийгдэж байгаа геологийн судалгааны ажлыг хэлэхээр тодорхойлжээ. Хууль зүйн нэр томъёоны хувьд мөн дээрх байдлаар²⁰ тайлбарлажээ.

“Ашигт малтмалын тухай хууль”-д 10 дугаар зүйлийн 10.1.7-т зааснаар төрийн захиргааны төв байгууллага нь “ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам батлах, бүтээгдэхүүний стандартыг боловсруулж батлуулах” бүрэн эрхийг эдэлдэг. Үүний дагуу Монгол Улсын уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 тушаалаар “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам” батлагдсан ба тус журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах зорилгоор явуулж буй геологи, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг зохицуулахаар заажээ. Тус журмын 1.4-т “Геологи, хайгуулын ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, оновчтой явуулах үүднээс геологийн судалгаа, эрлийн ажил, ашигт малтмалын ордын хайгуул гэсэн дэс дарааллаар гүйцэтгэнэ.” гэж ашигт малтмалын эрэл хайгуулыг тодорхойлсон байна. Мөн тус журмын Хоёрдугаар бүлэгт геологи, хайгуулын ажлын үндсэн үе шатыг дараах байдлаар журамлажээ. Үүнд:

- Талбайн геологийн тогтоц ба структур, ашигт малтмалын тархалт, түүний зүй тогтолыг судлах зорилготой холбогдох масштабын геологийн зураглал, ерөнхий эрэл, сэдэвчилсэн судалгааг геологийн судалгаа гэх бөгөөд үүний үр дүнд тогтоогдсон тодорхой төрлийн ашигт малтмалын илрэлийг баялгийн түвшинд (Р) үнэлнэ. Геологийн судалгааны ажлыг холбогдох зааврын дагуу гүйцэтгэнэ.
- Эрлийн ажлын хүрээнд ашигт малтмалын хуримтлал бүхий талбайг ялгах, түүний хэтийн төлөвийг тодорхойлж, цаашид хайгуулын ажил хийх эсэхийг тодорхойлох, эдийн засгийн ач холбогдлыг урьдчилан үнэлэхэд оршино. Энэ шатанд ашигт малтмалын илрэл, хүдрийн талбай, зангилаа зэрэг тодорхой талбайн хэмжээнд оновчтой масштабаар геологи, ашигт малтмалын болон бусад зургийг зохионо.
- Эрлийн талбайд эрлийн маршрут, геохими болон геофизикийн ажлыг дагалдах дээжлэлт, сорьцлолтын хамт явуулж, геологи, структурын болон бусад шаардлагатай зургуудыг зохиож, ашигт малтмалын биетийн тархалтыг судлах зорилгоор цөөн тооны гадаргуугийн уулын малталт, өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэж, эрдэс, геохимийн сарнилын хүрээ, геофизикийн гажлыг судалсан байна.
- Эрлийн ажлын үр дүнд тухайн ашигт малтмалын геологийн төрлийг тодруулж, нөөц эсвэл баялгийг (С болон Р1) үнэлж, геологийн урьдчилсан үнэлгээ хийж, тухайн ашигт малтмалын хайгуулын ажлын ач холбогдлыг тусгасан тайланг боловсруулж, орд хайгуулын ажил хийх үндэслэлийг тодорхойлсон байна. Тайланд тухайн ашигт малтмалын эдийн засгийн үнэлгээг тусгаж болно.

Ашигт малтмалын ордын хайгуулын ажил нь ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг тогтоон ашиглалтад бэлтгэх зорилготой байдаг.

- Ордын геологийн судлагдсан байдал, нөөц баялгийн зэрэглэл, ашигт малтмалын технологийн шинж чанар, эрдэс-бодисын бүрэлдэхүүн, чанарын хяналт бүхий сорьцлолт, лабораторийн судалгааны үр дүн, гидрогеологи, инженер-геологи, геоэкологи болон олборлох уул техникийн нөхцөл зэргийг

20 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (УБ, 2007), 52 дахь тал.

ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллын шаардлагын түвшинд судалж тогтоосон байна.

- Ашигт малтмалын ордыг ашиглахад шаардлагатай ахуйн болон үйлдвэрийн усны эх үүсвэр, түүний хангамжийг судлах, мөн ирээдүйн уурхайн үйлдвэрт шаардлагатай барилгын материалын үйлдвэрийн түүхий эдийн талаар зохих судалгааг хийсэн байна.
- Ашигт малтмалын геологийн нөөцөд үндэслэж ордыг ашиглах төслийн урьдчилсан геологи-эдийн засгийн үнэлгээ өгсөн байна.

Олборлолтын явцад хийх ордын ашиглалтын хайгуулын ажил нь олборлолтын ажлын төлөвлөлт, нөөцийн зэрэглэл өсгөх, хяналт, хөдөлгөөн хийх, хүдрийн биетийн хил хязгаар, тогтоц, байрших нөхцөл, нөөцийн хэмжээ, чанар болон гидрогеологи, уул техникийн нөхцөлийг нарийвчлан тодорхойлж тогтоох зорилготой.

Хайгуулын ажлын дүнд тогтоосон ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг шинжээчээр дүгнэлт гаргуулсны үндсэн дээр геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж хяналт тавьж зөвшөөрсөн хариу өгсөн тохиолдолд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох дүгнэлтийг гаргуулна.

Үүнээс гадна тус үйл ажиллагаанд баримтлах дараах зарчмуудыг Гуравдугаар бүлэгт зохицуулсан байна. Үүнд:

- Геологи, хайгуулын ажил нь шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой, иж бүрэн хийгдсэн байх;
- Геологи, хайгуулын ажлыг мэргэжлийн боловсон хүчин гүйцэтгэх бөгөөд хуулийн этгээд нь геологийн судалгаа, хайгуул, гидрогеологи, өрөмдлөг, геофизик, лабораторийн судалгааны ажил явуулах эрх бүхий байгууллага байх;
- Ашигт малтмалын орд, илрэлийг бүрэн судалж, ордод эдийн засгийн үнэлгээ өгсөн байх;
- Байгаль орчин, хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгодог байх.

1.6. “Түүхий эд” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг, 20.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20.14 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсэг, 24.5 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг, 29.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 29.11 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

Монгол хэлний их тайлбар тольд түүхий эд гэдгийг үйлдвэрийн газрын үндсэн хэрэглэгдэхүүн, дахин боловсруулж болох хаягдал гэж²¹ тайлбарласан байна. Англи хэлэнд тухайн нэр томьёог “raw material” гэж орчуулдаг бөгөөд ямар нэгэн зүйл хийх, бүтээхэд ашиглаж болох үндсэн материал²² гэж тодорхойлсон.

Эдийн засгийн шинжлэх ухааны үүднээс түүхий эд гэдгийг “Түүхий эд гэдэг нь бараа бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэл, үйлдвэрлэлд хэрэглэгддэг

21 Монгол хэлний их тайлбар толь, Холбоос: <https://mongoltoli.mn/dictionary/detail/8736>, Сүүлд үзсэн огноо: 2022.03.17.

22 *Raw material: Definition*, Холбоос: <https://www.britannica.com/dictionary/raw-material>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

материал, бодис юм. Түүхий эд гэдэг нь дэлхий даяарх түүхий эдийн биржээр худалдаалагдаж байгаа бараа бүтээгдэхүүн юм. Түүхий эд нь хөдөлмөр, капиталын нэгэн адил үйлдвэрлэлийн хүчин зүйл болдог тул худалдаачид хүчин зүйлийн зах зээл дээр түүхий эдийг худалдан авч зардаг. Түүхий эдийг олон төрлийн бүтээгдэхүүнд ашигладаг бөгөөд янз бүрийн хэлбэртэй байж болно. Түүхий эд гэдэг нь тухайн компани бүтээгдэхүүнээ үйлдвэрлэхэд шаардлагатай орц бүтээгдэхүүн юм. Жишээлбэл, тээврийн хэрэгсэл үйлдвэрлэхэд ашигладаг ган нь автомашин үйлдвэрлэгчийн түүхий эд болно.” гэж тайлбарласан байна. Түүхий эдийг дотор нь анхдагч түүхий эд болон хоёрдагч түүхий эд гэж хуваадаг.

Анхдагч түүхий эд

Анхдагч түүхий эд гэдэг нь сандал хийхэд ашиглах мод гэх мэт бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шууд ашигладаг материал юм. Анхдагч түүхий эдийг эргэлтийн хөрөнгөд байршуулж, борлуулсан бүтээгдэхүүний өртгийн хүрээнд орлогын тайланд тусгана. Жишээ нь мод болон модон бүтээгдэхүүн, зөөлөвч болон чигжээс, даавуу гэх мэтийг хамаруулна.

Хоёрдагч түүхий эд

Хоёрдагч түүхий эд нь эцсийн бүтээгдэхүүний нэг хэсэг биш харин үйлдвэрлэлийн процесст иж бүрэн ашиглагддаг. Хоёрдагч түүхий эдийг урт хугацааны хөрөнгө болгон бүртгэнэ. Жишээ нь холбох хэрэгсэл ба хадаас, модны цавуу, бээлий зэрэг ажилчдад зориулсан тоног төхөөрөмж гэх мэтийг хамаарна²³.

Эрүүгийн хуульд дараах түүхий эдүүдийг хуульчилсан байна. Үүнд:

1. Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эд
2. Эм, эмийн түүхий эд
3. Ховор, нэн ховор амьтны гаралтай түүхий эд
4. Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсгийн түүхийн эд

Тиймээс дээрх түүхий эдийн төрлүүдийг тус бүрт нь тодорхойлж, тохиолдол бүр дээр нь тодорхойлох арга замыг олох нь зүйтэй.

Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эд

1961 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”-д каннабис болон каннабисын давирхай, кока навчны кокаин, героин, кодэйн, неркодэйн гэх мэтчилэн нийт 2 бүлэг бүхий 140 гаруй мансууруулах эмийг жагсаалт байдлаар баталж тус мансууруулах эмийг гагцхүү анагаах ухааны болон эрдэм шинжилгээний хэрэглээгээр хязгаарлах, түүнээс бусад хэрэглээг хориглох, хяналт тавих, хэрэгжүүлэх тухай зохицуулсан²⁴.

1971 оны 2 дугаар сарын 21-ний “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-д этрифтамин, теноциклидин, зифефрол, фентиллин, амобарбитал, катин, лефетамин, мазиндол гэх мэт сэтгэцэд нөлөөлөх бодисыг жагсаалт болгон

23 *What Are Raw Materials?*, Холбоос: <https://www.investopedia.com/terms/r/rawmaterials.asp>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

24 *Convention on Narcotic Drugs, 1961*, Холбоос: <https://undocs.org/en/ST/CND/1/Add.1/Rev.8>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

оруулсан байна. Тус конвенцын зорилго нь сэтгэцэд нөлөөлөх зарим бодисыг урвуулан хэрэглэсний улмаас үүсэж байгаа олон нийтийн эрүүл мэнд, нийгмийн асуудлыг сэтгэл зовнин тэмдэглэж, тийм бодисыг урвуулан хэрэглэх, түүнээс үүсдэг хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бөгөөд тухайн конвенцоор сэтгэцэд нөлөөлөх бодисыг хязгаарлах, хориглох, хяналт тавих, хэрэгжүүлэх асуудлыг зохицуулдаг байна²⁵.

Үүнээс үзэхэд дээрх хоёр конвенцэд хамаарах түүхий эдийг хамааруулахаар тус нэр томьёоны агуулга тодорхойлогдож байна.

Мансууруулах эмийн хувьд кока навч, намуу цэцгийн баяжмал, опиум зэрэг материалууд түүхий эд болдог байна²⁶. Харин сэтгэцэд нөлөөт бодисын хувьд 1971 оны 2 дугаар сарын 21-ний “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-д заасан этрифтамин, теноциклидин, зифефрол, фентиллин, амобарбитал, катин, лефетамин, мазиндол гэх мэт сэтгэцэд нөлөөлөх бодисын түүхий эд хамаарахаар байна.

Эм, эмийн түүхий эд

Эм, эмийн түүхийн эдэд 7-Аминодцефалоспораны хүчил (7-ADCA), цууны хүчил, аланин, архи, алгинатууд, хөнгөн цагаан формат, амин хүчил, аммонийн цахиурын фторид, кальцийн цитрат, кальцийн гидроксид, кальцийн стеарат, карбоксиметилцеллюлоз натри, карагенан, целлюлоз, микрокристалл, сахарин натри, натрийн ацетат, натрийн аскорбат, натрийн бензоат, натрийн бикарбонат, натрийн бромид гэх мэт 100 гаруй төрлийн түүхий эд хамаардаг байна²⁷.

Ховор, нэн ховор амьтны гаралтай түүхий эд

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан “Амьтны тухай” хуулийн 4.1.3, 4.1.4 дэх хэсэгт зааснаар ховор амьтныг тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг гэж, нэн ховор амьтныг тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг хэлнэ гэж тодорхойлсон. Тухайн амьтдын гаралтай түүхий эдүүд нь тухайн ойлголтод хамаарахаар байна. Амьтдын гаралтай түүхий эдэд үслэг, ангор үс, ноос, ноолуур, альпако ноос, сахал, зарааны үс, арьс, өд, эвэр, яс зэрэг түүхий эдүүд хамардаг²⁸.

Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсгийн түүхийн эд

Хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг гэдэгт хүчтэй дэлбэрэлт үүсгэх, радио идэвхт материалуудын тусламжтайгаар үйлчилдэг хүн амыг үй олноор нь устгах, гэмтээх үйлчилгээтэй Монгол Улсын олон улсын гэрээгээр

25 *Convention on psychotropic substances*, 1971, Холбоос: https://www.unodc.org/pdf/convention_1971_en.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

26 *Narcotic raw materials*, Холбоос: https://www.incb.org/pdf/e/estim/trainmat/NAR_1%20English%202005.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

27 *Chemicals & Raw Materials*, Холбоос: <https://www.pharmamanufacturingdirectory.com/category/chemicals-raw-materials>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

28 *Animal-Derived Raw Material Product Standards*, Холбоос: <https://corporate.target.com/sustainability-ESG/environment/animal-welfare/animal-derived-raw-materials>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

хориглосон хими, биологийн, цөмийн зэвсэг юм²⁹.

Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсгийн хувьд Монгол Улсын нэгдэн орсон Цөмийн зэвсгийг агаар мандал, огторгуйн уудам, усан дор туршихыг цаазлан хориглох тухай Москвагийн гэрээ, Амьсгал боогдуулагч, хортой буюу бусад иймэрхүү хий болон бактериологийн зэвсгийг дайнд хэрэглэхийг цаазлан хориглох тухай Женевийн протокол, Цөмийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх тухай Москвагийн гэрээ, Бактериологийн болон хорт нянгийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглож устгах тухай Вашингтон, Лондон, Москвагийн конвенц, Химийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах тухай конвенц гэх мэт конвенцуудад хориглосон зэвсгүүдийг ойлгоно.

Түүхий эдийн тухайд химийн зэвсгийн хувьд Азотын гич (HN), Мэдрэлийн агентууд Табун (GA), Сарин (ГБ), Соман (GD), Циклозарин (GF), VX (VX), Цианоген хлорид (СК), Устөрөгчийн цианид (АС) гэх мэт түүхий эдүүд³⁰, биологийн зэвсгийн хувьд бактери, вирус, риккетси, мөөгөнцөр, хорт бодис эсвэл бусад биологийн бодисууд³¹ хамаарч байна.

1.7. “Байгалийн тэнцэл” гэх нэр томъёоны тухайд.

Тус нэр томъёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 24.9 дүгээр зүйлд тусгагдсан байна. Эрүүгийн хуульд тухайн нэр томъёог гэмт хэргийн бүрэлдэхүүний түвшинд “Амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсан” гэх байдлаар тайлбарласан байна. Дээрхээс дүгнэвэл амьтан, ургамлын зүйл, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөц болон бусад хэлбэрийн экологийн тогтолцоог байгалийн тэнцэл гэж ойлгохоор хуульчилжээ.

Байгалийн тэнцэл алдагдуулах гэдгийг англиар ecocide, оросоор экоцид гэдэг бөгөөд ерөнхийдөө экоцид гэдэг нэр томъёогоор илэрхийлдэг. Хууль зүйн нэр томъёоны тайлбар тольд экоцид гэдгийг “ургамлын буюу амьтны аймгийг бөөнөөр, үй олноор нь устгах, агаар буюу усны нөөцийг хордуулах, түүнчлэн экологийн сүйрэлд хүргэж болзошгүй өөр үйлдэл хийх, энх тайван, аюулгүй байдал ба хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг. Сүүлийн жилүүдэд олон улсын эрх зүйд экоцидыг олон улсын гэмт хэрэг хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага ажиглагдаж байна³²” гэж тайлбарласан байна.

Экоцид гэдэг үг нь Грек хэлний “oikos” буюу гэр/байшин (дараа нь хүний оршин буй газар, хүрээлэн буй орчин), “cide” буюу алах гэсэн үгнээс бүрддэг. 1944 оны 11-р сард “геноцид” гэсэн үгийг зохион бүтээсэн Польшийн хуульч Рафаэль Лемкин энэхүү арга барилаар тухайн үгийг зохион бүтээсэн юм³³. Профессор Артур

29 С.Гантулга, Б.Энхбаяр нар, *Эрүүгийн эрх зүй, тусгай анги сурах бичиг*, (УБ, 2018), 557 дахь тал.

30 “Types of Chemical Weapons” (PDF), www.fas.org, Federation of American Scientists, Archived from the original (PDF) on March 3, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

31 *Britannica: biological weapon*, <https://www.britannica.com/technology/biological-weapon>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

32 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (УБ, 2007), 620-621 дэх тал.

33 *Stop Ecocide foundation: Independent Expert Panel for the Legal Definition of Ecocide commentary and core text*, June 2021, Холбоос: <https://static1.squarespace.com/static/5ca2608ab914493c64ef1f6d/t/60d1e6e604fae2201d03407f/1624368879048/SE+Foundation+Commentary+and+core+text+rev+6.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

В.Галстон “Экоцид” гэсэн нэр томьёог анх гаргасан. Профессор Галстон Вашингтонд болсон Дайн ба үндэсний хариуцлагын асуудлаарх бага хурал дээр “экоцид” гэсэн ойлголтыг дэвшүүлсэн бөгөөд тэрээр мөн экоцидийг хориглох олон улсын шинэ хэлэлцээрийг санал болгосон. Дараа нь био ёс зүйч мэргэжилтэй тэрээр 1970 онд анх удаа экосистемийн асар их хохирол, сүйрлийг экоцид гэж тодорхойлсон³⁴.

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд экоцидыг тайлбарлаж дайны гэмт хэрэгт тооцсон. Тус олон улсын гэрээ нь 1998 оны 07 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан, 2002 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 2002 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр нэгдэж орсон байна. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 8 дугаар зүйл буюу “Дайны гэмт хэрэг” гэдгийг тодорхойлсон хэсгийн “iv”-т “тухайн халдан довтлох явдал нь энгийн хүмүүс амь насаа тохиолдлоор алдах буюу гэмтэх, эсхүл иргэний байгууламжид хохирол учруулах, эсхүл цэргийн тодорхой болон шууд тооцон хүлээж байгаа ердийн давуу байдалтай жиших аргагүй өргөн, урт хугацааны болон ноцтой хохирлыг хүрээлэн байгаа орчинд учруулахыг мэдсээр байж санаатайгаар халдан довтлох” гэж геноцидыг тодорхойлсон байна.

Олон улсын “Экоцид”-ын хуультай холбоотой тодорхойлолт, түүх, хэвлэгдсэн судалгаа, одоо мөрдөж буй хууль тогтоомж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга шинэчлэгддэг материалын цуглуулгыг хангадаг иж бүрэн нөөцийн төв болох Ecocidelaw-аас тухайн тодорхойлолтын нэр томьёог дараах байдлаар ойлгож байх зөвлөмжийг өгсөн байна.

“Ноцтой” - Хүний амь нас, байгаль, соёл, эдийн засгийн нөөцөд ноцтой нөлөөлөл үзүүлэх зэрэг хүрээлэн буй орчны аль нэг элементэд маш ноцтой сөрөг өөрчлөлт, эвдрэл, хохирол учруулсан хохирлыг хэлнэ.

“Өргөн хэмжээний” - Газарзүйн хязгаарлагдмал бүс нутгаас хэтэрсэн, улсын хилийг давсан, эсхүл бүхэл бүтэн экосистем, төрөл зүйл, олон тооны хүн төрөлхтөнд учирсан хохирлыг хэлнэ.

“Урт хугацааны” - Нөхөж баршгүй буюу боломжийн хугацаанд байгалийн нөхөн сэргээх замаар нөхөн сэргээх боломжгүй хохирлыг хэлнэ.

34 Ecocidelaw:History, Холбоос: <https://ecocidelaw.com/history/>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

“Хүрээлэн байгаа орчин” - Дэлхий, түүний шим мандал, криосфер, литосфер, гидросфер, агаар мандал, түүнчлэн сансар огторгуйг хэлнэ³⁵.

Дээрхээс гадна эковицыг дотоодын хууль тогтоомжид улс, орнууд хуульчилж эхэлсэн. Өөрөөр хэлбэл эковицыг зөвхөн дайны гэмт хэрэг бус тухай улсын эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжид багтах гэмт хэрэг гэж тооцсон байна. Тухайлбал, 1990 онд Вьетнам улс хамгийн анх удаа, 1996 онд Оросын холбооны улс, 1997 онд Казакстан, 1998 онд Киргизын бүгд найрамдах улс, Тажикстан улс, 1999 онд Гүрж улс, Беларус улс, 2001 онд Украин улс, 2002 онд Молдав улс, 2003 онд Армен улс дотоодын эрүүгийн хууль тогтоомждоо эковицыг хуульчилсан байна. Зохицуулалтуудыг авч үзвэл:

- Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн 358 дугаар зүйлд эковицыг “Ургамлын төрөл зүйл буюу амьтны аймгийг үй олноор нь устгасан, агаарын буюу усны нөөцийг хордуулсан, түүнчлэн экологийн сүйрэлд хүргэж болохуйц бусад үйлдэл хийсэн бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”
- Казакстан Улсын Эрүүгийн хуулийн 161 дүгээр зүйлд эковицыг “Ургамал, амьтныг үй олноор нь устгах, агаар мандал, газар, усны нөөцийг хордуулах, түүнчлэн экологийн сүйрэлд хүргэсэн, эсхүл хүргэж болзошгүй бусад үйлдэл хийх”
- Украин Улсын Эрүүгийн хуулийн 441 дүгээр зүйлд эковицыг “Ургамал, амьтныг үй олноор нь устгах, агаар, усны нөөцийг хордуулах, түүнчлэн байгаль орчны гамшигт хүргэж болзошгүй аливаа үйл ажиллагаа” гэж тус тус зохицуулсан байна.

Дээрхээс дүгнэвэл, эковид гэдэг нь олон улсын гэрээнд тусгагдсан тодорхой төрлийн дайны гэмт хэрэг болох нь харагдаж байна. Үүнийг ихэвчлэн пост-социалист улсууд Эрүүгийн хуульдаа тусгасан байна. Ингэж тусгахдаа байгалийн тэнцлийг алдагдуулах, хор учруулах байдлыг ихэвчлэн амьтан, ургамлыг үй олноор нь устгасан, агаар, газар, усны нөөцийг хордуулсан, байгаль орчны гамшигт хүргэж болзошгүй бусад үйлдлийг хамааруулахаар зохицуулжээ. Монгол Улсын хувьд дээрх жишгийн дагуу Эрүүгийн хуульдаа тус гэмт хэргийг зохицуулсан ба “амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсан” гэж төсөөтэй зохицуулсан байна. Харьцуулбал “Амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан” гэж зохицуулсны тухайд явцуу хүрээнд тодорхойлсон бөгөөд үй олноор нь устгасан тохиолдлыг зөвхөн хамруулахаар ойлгож, тодорхойлох нь зүйтэй. Учир нь өмнө нь тодорхойлсноор энэхүү үйлдэл нь ноцтой, өргөн хэмжээний, урт хугацааны хохирол учруулахаар байх ёстой. Дээр нөхцлийг хангасан тохиолдолд байгалийн тэнцэл алдагдаж, эковид үүсгэгдэнэ. Бусад нөхцлийн тухайд олон улсын гэрээний зохицуулалт, бусад улс орны жишиг, хүрээлэн буй орчны тодорхойлолтод бүрэн нийцэж байна.

35 *Stop Ecocide foundation:Independent Expert Panel for the Legal Definition of Ecocide commentary and core text*, June 2021, Холбоос: <https://static1.squarespace.com/static/5ca2608ab914493c64ef1f6d/t/60d1e6e604fae2201d03407f/1624368879048/SE+Foundation+Commentary+and+core+text+rev+6.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

II. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА

2.1. “Төрийн нууц” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 19.4 дүгээр зүйлийн 1,2 дэх хэсэг, 19.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 19.12 дугаар зүйл, 19.13 дугаар зүйл, 26.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.2-т тус тус тусгагдсан байна.

Олон улсын тайлбар тольд State secret буюу төрийн нууц гэж засгийн газраас шийдвэр гаргасан нууцалсан мэдээлэл гэж тайлбарласан.³⁶ Мөн зөвхөн засгийн газар болон түүний ажилтнуудын мэддэг мэдээлэл, түүний хэсэг³⁷ гэж тайлбарласан байна.

1995 оны Төрийн нууцын тухай хууль, 2004 онд батлагдсан Төрийн нууцын жагсаалттай холбоотой. Харин 2017 оны Төрийн болон албаны нууцын тухай хуулиар “Төрийн нууц” -ыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдалд, үндэсний ашиг сонирхолд аюул, занал хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно хэмээн хуульчилсан.³⁸ Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Дугаар 247 тогтоолоор “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг баталсан.³⁹ Төрийн болон албаны нууцын тухай хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээллийг авч үзвэл, 1. Төрийн бодлогын хүрээнд 9, 2. Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд 4, 3.Батлах хамгаалах хүрээнд 15, 4. Тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд 18, 5. Мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд 14 мэдээллийг төрийн нууцад хамааруулсан байна.⁴⁰

Харин Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Дугаар 247 тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтаас харвал, монгол улсын их хурлын тамгын газар 31, монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар 16, засгийн газрын хэрэг эрхлэх газар 32, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, стратегийн судалгааны хүрээлэн 33, гадаад харилцааны салбар 19, батлан хамгаалах салбар 78, хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбар 56, банк, санхүүгийн салбар 21, байгаль орчин, аялал жуулчлалын салбар 10, барилга, хот байгуулалтын салбар 14, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар 9, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар 11, зам, тээврийн салбар 10, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 10, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар 12, эрүүл мэндийн салбар 10, эрчим хүчний салбар

36 Холбоос: <https://www.macmillandictionary.com/dictionary/british/state-secret>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

37 *Cambridge dictionary: Official secret*, Холбоос: <https://dictionary.cambridge.org/dictionary/english/official-secret>, Сүүлд үзсэн огноо: 2022.02.15.

38 Төрийн болон албаны нууцын тухай хууль (2017), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/12408>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

39 Монгол улсын засгийн газрын тогтоол, дугаар 247 (2017), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/12878>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

40 *Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ*, (УБ, 2019), *Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ* (gic.mn), Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

12, авлигатай тэмцэх газар 20, төрийн аудитын байгууллага 6, сонгуулийн ерөнхий хороо 5, санхүүгийн зохицуулах хороо 4, үндэсний статистикийн хороо 5, цөмийн энергийн комисс 6, төрийн албаны зөвлөл 7, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар 9, мэргэжлийн хяналтын байгууллага 5, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 7, үндэсний хөгжлийн газар 5, тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газар 60, онцгой байдлын салбар 13, стандарт, хэмжил зүйн газар 4, монгол улсын үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллага 13, аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар 17 гэх нийт 570 мэдээллийг төрийн нууцад хамруулан үзжээ.⁴¹

2.2. “Садар самуун” гэх нэр томъёоны тухайд.

Тус нэр томъёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

Бэлгийн дур хүсэл бий болгох зорилготой ном зохиол, кино, хөшөө, зураг мөн бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр бэлгийн зан үйлийг харуулсан дүрслэл юм. Pornography болон erotica-гийн ялгаа нь субъектив ба нийгмийн стандартаас хамааран өөрчлөгдөж байдаг. Pornography гэх үг нь Грекийн pornē (биеэ үнэлэгч) мөн graphēin (бичих) гэсэн үгнээс гаралтай ба энэ үг нь анх бие үнэлэгчдийн амьдралыг харуулсан аливаа урлагийн ба уран зохиолын бүтээл гэж тодорхойлжээ.⁴² Мөн бэлгийн дур хүслийг төрүүлэх зорилготой бэлгийн үйлдэл, нүцгэн хүмүүсийг дүрсэлсэн эсвэл харуулсан уран сайхны үнэ цэнэ байхгүй ном, сэтгүүл, кино гэх мэт⁴³ гэж тодорхойлжээ.

Монгол улсын Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 3.1.1-т “садар самууныг сурталчлах” гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг гэж заасан. Үүнээс үзвэл садар самуун гэдэг нь бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр үзүүлсэн байдлыг илэрхийлнэ.

41 Монгол улсын засгийн газрын тогтоол, дугаар 247 (2017), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/12878>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

42 *Pornography: sociology*, By John Philip Jenkins, Холбоос: <https://www.britannica.com/topic/pornography>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

43 *Cambridge dictionary: Pornography*, Холбоос: <https://dictionary.cambridge.org/dictionary/english/pornography>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

III. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА

3.1. “Валют, Валютын ханш” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 18.2 дугаар зүйлд тусгагдсан байна.

Валют гэдэг нь нэгдүгээрт улс орны мөнгөний нэгж, түүний хэв маяг/алтан, мөнгөн, цаасан/, хоёрдугаарт олон улсын тооцоонд ашигладаг гадаад улсын мөнгөн тэмдэгт, гуравдугаарт үндэсний тооцооны нэгж, төлбөрийн хэрэгсэл, дөрөвдүгээрт Монгол улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлс юм⁴⁴.

Валютын ханш гэдэг нь (русс: валютные курс, англ: course of exchange, rate of exchange) тухайн улсын мөнгөний гадаадын валют, олон улсын валютын нэгжээр илэрхийлэгдэх “үнэ”. Өөрөөр хэлбэл худалдан авах өртөг ба бусад хүчин зүйлсээр тодорхойлогддог үндэсний ба гадаадын валютын харьцаа юм. Валютын ханшинд худалдан авах чадвар, төлбөрийн баланс, зээлийн хүү, валютын захын үйл ажиллагаа, олон улсын зах зээл дээр тухайн валютад итгэх итгэлийн түвшин, валютын ханшинд хийх төрийн зохицуулалт зэрэг хүчин зүйлсүүд нөлөөлдөг. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг Монгол банк валютын зах зээл дээр арилжааны банкуудын худалдсан, худалдаж авсан гадаад валютын ханшинд үндэслэн тус улсын гадаад худалдаанд зонхилон хэрэглэж байгаа тогтвортой ханш бүхий чөлөөтэй хөрвөдөг аль нэг гадаад улсын валютын тухайн үеийн ханштай жишин тогтоож нийтэд зарлана⁴⁵.

Валютын зохицуулалтын тухайд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төгрөг, юаний своп хэлцлийн журам, Валютын своп, форвард хэлцлийн журам зэрэг хууль, журмууд болон Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалуудаар⁴⁶ зохицуулагддаг. Валют гэдгийг 1994 оны “Валютын зохицуулалтын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 1-т зааснаар Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хэлнэ гэж тодорхойлсон. Мөн тухайн хуулийн 3 дугаар зүйлийн 2-т зааснаар үндэсний валютыг эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөг, түүгээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгсэл гэж, 3-т зааснаар гадаад валютыг эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий нэг буюу хэд хэдэн гадаад улсын мөнгөн тэмдэгт, тэдгээрээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ. Гадаад валютыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрснөөр чөлөөтэй хөрвөдөг гэж, 4-т зааснаар мөнгөжсөн алтыг олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, олон улсын санхүүгийн аль нэг төвд хадгалуулж байгаа, гадаад валютаар борлуулахад бэлэн болсон алтыг гэж, валютын үнэт зүйл гэдгийг мөнгөжсөн алттай адилтгах үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ гэж тус тус тодорхойлсон байна.

44 Монгол банк, Дэлхийн банк, *Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь*, (УБ, 2015).

45 Монгол банк, Дэлхийн банк, *Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь*, (УБ, 2015).

46 Валют зохицуулалтын талаар эрх зүйн актууд, Холбоос: <https://www.mongolbank.mn/listlawsandregulationsdb.aspx?id=4>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

2009 оны “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн 3.1.5-т зааснаар гадаад валютыг гадаадын мөнгөн тэмдэгт, гадаадын валютыг хэлнэ гэж тодорхойлсон байна. Харин тухайн хуулиудад валютын ханш гэх нэр томъёоны талаар ТАЙЛБАРЛАСАН ТОДОРХОЙЛОЛТ БАЙХГҮЙ.

IV. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА

4.1. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3, 20.7 дугаар зүйлийн 1, 2 дэх хэсэг, 20.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 20.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

Мансууруулах эмийг “narcotic drug”, сэтгэцэд нөлөөт бодисыг “psychotropic substance” гэсэн утгаар нь ойлгож, орчуулдаг. Хавдар судлалын зүгээс мансууруулах эмийг “дунд зэргийн болон хүнд хэлбэрийн өвдөлтийг эмчлэхэд хэрэглэдэг бодис; Мансууруулах эм нь морфин, кодеин зэрэг опиаттай адил боловч опиум буюу хар тамхинаас гаргаж авдаггүй; Тэд төв мэдрэлийн систем дэх опиоид рецепторуудтай холбогддог; Мансууруулах эмийг одоо опиоид гэж нэрлэдэг болсон.⁴⁷” гэж тайлбарладаг бол сэтгэцэд нөлөөлөх бодисыг “тархины үйл ажиллагаанд нөлөөлж, сэтгэлийн байдал, ухамсар, бодол санаа, мэдрэмж, зан төлөвт өөрчлөлт оруулдаг мансууруулах бодис эсвэл бусад бодис; Сэтгэц нөлөөт бодисын жишээнд алкохол, кофеин, никотин, марихуан болон зарим өвдөлт намдаах эмүүд орно; Героин, LSD, кокаин, амфетамин зэрэг олон хууль бус хар тамхи нь сэтгэцэд нөлөөт бодис юм.⁴⁸” гэж тодорхойлсон. Мөн өөр төрлийн анагаахын шинжлэх ухааны толь бичигт сэтгэцэд нөлөөлөх бодисыг “Таашаалыг өгдөг бодисын хэрэглээтэй эсвэл өвдөлтийг намдаадаг, бие махбодын хамаарал, хүлцлийг үүсгэдэг, ижил үр дүнд хүрэхийн тулд тунгаар хэрэглэх хандлагатай бодис, жоргүй сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх нь “нийгмийн” эсвэл тохиолдлын шинжтэй, эсвэл илэн далангүй донтолт болж хувирдаг, донтуулах чадвартай кокаин/‘хагарал’, амфетамин, опиат, никотин, спирт, бензодиазепин, барбитурат, каннабис, галлюциноген, кофеин, эмчилгээний эм буюу эмнэлзүйн орчинд зохистой ажиллах чадварыг сайжруулдаг бодис⁴⁹” гэж, сэтгэцэд нөлөөлөх бодисыг “Опиум эсвэл опиумтай төстэй нэгдлээс гаргаж авсан морфин, героин зэрэг мансууруулах бодис нь өвдөлтийг намдаадаг, ихэвчлэн нойрыг хүргэдэг, ухамсрыг өөрчилдөг, донтуулдаг.⁵⁰” гэж тус тус тайлбарласан байна.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тухайн нэр томьёог мөн тайлбарласан байна. 1988 оны 12 дугаар сарын 20-ны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц”-ын 1 дүгээр зүйлийн п хэсэгт мансууруулах эм гэдгийг Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенц болон нэмэлт өөрчлөлт оруулсан уг конвенцийн I жагсаалт, II жагсаалтад орсон байгалийн болон нийлэг аливаа бодисыг хэлнэ гэж, 1 дүгээр зүйлийн г хэсэгт сэтгэцэд нөлөөлөх бодис гэж 1971 оны конвенцийн I, II, III, IV жагсаалтад орсон байгалийн буюу нийлэг аливаа бодис эсхүл байгалийн аливаа материалыг хэлнэ гэж тус тус тодорхойлсон.

47 National cancer institution, *Dictionary of cancer terms*, Холбоос: <https://www.cancer.gov/publications/dictionaries/cancer-terms/def/narcotic>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

48 National cancer institution, *Dictionary of cancer terms*, Холбоос: <https://www.cancer.gov/publications/dictionaries/cancer-terms/def/psychotropic-substance>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

49 Medical dictionary by Farlex, Холбоос: <https://medical-dictionary.thefreedictionary.com/psychotropic+substances>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

50 Medical dictionary by Farlex, Холбоос: <https://medical-dictionary.thefreedictionary.com/narcotic+drug>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

1961 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”-д каннабис болон каннабисын давирхай, кока навчны кокаин, героин, кодэйн, неркодэйн гэх мэтчилэн нийт 2 бүлэг бүхий 140 гаруй мансууруулах эмийг жагсаалт байдлаар баталж тус мансууруулах эмийг гагцхүү анагаах ухааны болон эрдэм шинжилгээний хэрэглээгээр хязгаарлах, түүнээс бусад хэрэглээг хориглох, хяналт тавих, хэрэгжүүлэх тухай зохицуулсан⁵¹.

1971 оны 2 дугаар сарын 21-ний “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-д этрифтамин, теноциклидин, зифефрол, фентиллин, амобарбитал, катин, лефетамин, мазиндол гэх сэтгэцэд нөлөөлөх бодисыг жагсаалт болгон оруулсан байна. Тус конвенцын зорилго нь сэтгэцэд нөлөөлөх зарим бодисыг урвуулан хэрэглэсний улмаас үүсэж байгаа олон нийтийн эрүүл мэнд, нийгмийн асуудлыг сэтгэл зовнин тэмдэглэж, тийм бодисыг урвуулан хэрэглэх, түүнээс үүсдэг хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бөгөөд тухайн конвенцоор сэтгэцэд нөлөөлөх бодисыг хязгаарлах, хориглох, хяналт тавих, хэрэгжүүлэх асуудлыг зохицуулдаг байна⁵².

4.2. “Халдварт өвчин” гэх нэр томъёоны тухайд.

Тус нэр томъёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2 дэх хэсгийн 2.5, 12.5 дугаар зүйлийн 2 дэх хэсгийн 2.2, 15.6 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг, 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 19.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

Оксфордын анагаахын товч тайлбар тольд халдварт өвчнийг “нэг хүнээс нөгөөд дамжих бүхий л өвчин. Энэ нь бие махбодтой шууд харьцах, халдвартай бичил биетнийг авсан объекттой нийтлэг харьцах, өвчин тээгчээр дамжуулан, эсвэл ханиалгах эсвэл амьсгалын замаар халдвар бүхий дуслыг агаарт тараах зэргээс үүдэлтэй байж болно.”⁵³

Харвардын Их Сургуулийн эрүүл мэндийн хэвлэх газраас эрхлэн хэвлүүлсэн Анагаахын шинжлэх ухааны толь: эрүүл мэндийн нэр томъёо номд халдвар гэх үгийг “хүний бие махбодид бактер гэх мэт өвчин үүсгэх аюултай организмын өсөлт.”⁵⁴ хэмээн тайлбарлаад, халдварт өвчнийг “Хүнээс хүнд халдварладаг бактери, вирус болон бусад эмгэг төрүүлэгч бичил биетүүдээс үүдэлтэй аливаа өвчин.”⁵⁵ хэмээн тодорхойлсон байна.

Мэд тэрмсийн Анагаахын шинжлэх ухааны тольд халдварт өвчнийг тодорхойлохдоо “өвчин (томуу, хумхаа, менингит, галзуу, татран гэх мэт) өвчин үүсгэгч бодис, бичил биетүүд (бактер, вирус, эгэл биетэн, мөөгөнцөр гэх мэт) хүний биед нэвтэрч, тэнд төлжиж, үржихийг хэлнэ.”⁵⁶

51 Convention on Narcotic Drugs, 1961, Холбоос: <https://undocs.org/en/ST/CND/1/Add.1/Rev.8>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

52 Convention on psychotropic substances, 1971, Холбоос: https://www.unodc.org/pdf/convention_1971_en.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

53 Oxford concise medical dictionary, Холбоос: www.oxfordreference.com, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

54 Harvard Health Publishing, Medical Dictionary of Health Terms: D-I, Холбоос: <https://www.health.harvard.edu/d-through-i#l-terms>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

55 Мөн тэнд, Холбоос: <https://www.health.harvard.edu/a-through-c#C-terms>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

56 MedTerms Medical Dictionary A-Z, Холбоос: <https://www.medicinenet.com/infection/definition.htm>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

Хууль зүйн хувьд “халдварт өвчин”, “бэлгийн замын халдварт өвчин” гэх нэр томьёог хууль, бусад эрх зүйн акт, УДШ-ийн тайлбарт тодорхойлж, тайлбарлаагүй байна. Харин “дархлал хомсдолын вирус” гэх нэр томьёог Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт тодорхойлсон байна.

4.3. “Ураг зулбасан” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тус тусгагдсан байна.

Хууль зүйн нэр томьёоны хувьд тухайн нэр томьёог бусад хууль, журамд тайлбарласан тайлбар байхгүй байна. Харин эрх зүйн нэвтэрхий тольд “ураг зулбасан” гэх нэр томьёог амьдрах чадваргүй ураг аяндаа болон өөрийн эрхгүй дутуу гарахыг хэлэх ба үүнийг өөрөөр аяндаа үүсэх үр хөндөлт гэж нэрлэдэг⁵⁷. Мөн “ураг” гэдгийг хөгжиж буй боловч төрөөгүй хөхтөн амьтан, ялангуяа хөгжлийн сүүлийн үе шатанд явааг хэлнэ гэж тодорхойлсон. Энэхүү нэр томьёо нь хууль зүйн нэр томьёо бус харин анагаахын шинжлэх ухааны нэр томьёо учраас түүний тайлбарыг тухайн шинжлэх ухааны тодорхойлолттой уялдуулж тайлбарлах нь зүйтэй.

“Ураг зулбах” гэдгийг англиар miscarriage, “ураг” гэдгийг fetus гэж нэрлэдэг байна. Анагаахын шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толиудад тухайн нэр томьёог дараах байдлаар тодорхойлсон байна.

“Ураг” гэж эхийн умайд өсч буй хүний үр төлийн наймдах долоо хоногоос хойшхи үе⁵⁸ юм.

“Ураг” гэж эмбрионы үе дуусах үе буюу жирэмсний 10 дахь долоо хоног дуусах үед эмбрион нь ураг болохыг хэлдэг. Өөрөөр хэлбэл ураг гэдэг нь жирэмсний 11 дэх долоо хоногоос өсөж буй хүүхэд юм⁵⁹.

“Ураг” гэж тухайн зүйлийнхээ ерөнхий бүтэц болон хэлбэрийг авсны дараа төрөөгүй байх аливаа сээр нуруутан амьтдын, ялангуяа хөхтөн амьтны төл⁶⁰ юм.

“Ураг” гэж хөгжлийн найм дахь долоо хоногоос хойш төрөөгүй хүүхдийг хэлнэ⁶¹.

“Ураг зулбах” гэдэг нь ургийг хэвийн амьдрах чадвартай болохоос нь өмнө буюу жирэмсний 24 долоо хоногоос өмнө гадагшлуулахыг хэлнэ⁶².

“Ураг зулбах” гэж жирэмслэлтийн 20 дахь долоо хоногоос өмнө үр хөврөл эсвэл ураг эхийн дэмжлэггүйгээр амьдрахад хангалттай хөгжихөөс өмнө умайгаас аяндаа гадагшлуулахыг хэлнэ⁶³.

57 Bryan A. Garner, *Black's law dictionary: Eighth edition*, (8th ed. 2004), p.3162.

58 П.Нямдаваа, Н.Наранбаатар, Н.Наранбат, Н.Наранболд нар, *Анагаах ухааны нэр томьёоны товч тайлбар толь*, (УБ, 2006), 104 дэх тал.

59 *Embryo vs. fetus week by week*, Холбоос: https://www.medicinenet.com/embryo_vs_fetus_differences_week-by-week/article.htm, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

60 *Britannica:fetus*, Холбоос: <https://www.britannica.com/science/fetus>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

61 Dr. Harvey Marcovitch, *Black's medical dictionary*, (41st ed. 2005), p.269.

62 Dr. Harvey Marcovitch, *Black's medical dictionary*, (41st ed. 2005), p.3.

63 *Britannica:Miscarriage*, Холбоос: <https://www.britannica.com/science/miscarriage> Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

“Ураг зулбах” гэж ургийг амьдрах чадвартай болохоос өмнө жирэмслэлтийг санамсаргүйгээр алдахыг ойлгоно⁶⁴.

Дээрхээс дүгнэвэл “ураг” гэдэг нь жирэмсний 8-10 дахь долоо хоногийн дараа бий болох тухайн эхийнхээ бүтэц, хэлбэрийг агуулсан төрөөгүй, амьдрах чадваргүй төл, хүүхэд байна. Харин “ураг зулбах” гэдэг нь жирэмсний 20-24 дэх долоо хоног дотор хэвийн амьдрах чадваргүй ургийг биеэсээ гадагшлуулахыг хэлэхээр байна.

Энэхүү ойлголтоор тайлбарлавал “ураг зулбах” гэх нэр томъёо нь зөвхөн 8-10 дахь долоо хоногийн дараагийн жирэмслэлт, түүнд хамаарах хүүхдэд хамааралтай байхаар байна. Гэвч үүнээс өмнөх үе буюу эмбрион үе шатыг тухайн нэр томъёонд мөн хамааруулж авч үзэх шаардлага гарч байна. Эмбрион гэдэг нь хоёр дахь сар дуусахаас өмнө хэвлийд байгаа ураг⁶⁵ бөгөөд үр тогтолт, хуваагдал, өсөлтийн эхэн үед байгаа организм⁶⁶ юм.

Ураг буюу фетус болон үр хөврөл буюу эмбрийн тухайд дараах шинжүүдээр хоорондоо ялгагддаг байна. Үүнд:

- Жирэмсний хугацаанаас хамаарч ялгаа нь илэрдэг буюу нэг нь нөгөөдөө хувирдаг;
- Үр хөврөл нь хүний хөгжлийн эхний үе шат бөгөөд үүнд хүний чухал эрхтнүүд үүсдэг;
- Үр хөврөлийн үе бол бие махбодийн чухал тогтолцоог бүрдүүлэх явдал юм;
- Үр хөврөлийн зүрхний цохилт зургаан долоо хоног орчим эхэлдэг.⁶⁷

Дээрхээс үзвэл жирэмсэн байх үед эхийн хэвлийд байх хүүхдийг зөвхөн ураг байх үед нь эрх зүйн хамгаалалтад авч байгаа нь харагдаж байгаа бөгөөд үр хөврөлийн буюу эмбрийн үед түүнийг эрх зүйн хамгаалалтад авахгүй байхаар хуульчилсан байна.

Гадаад улсуудын хувьд ураг болон үр хөврөлийг адилхан статусаар хуульчилж эрх зүйн хамгаалалтад авах тохиолдолд цөөнгүй байна. Тухайлбал Америкийн нэгдсэн улсын 2004 оны “Төрөөгүй хохирогчийн хүчирхийллийн тухай” гэх нэртэй актад Холбооны 60 гаруй гэмт хэргийн аль нэгийг үйлдэх явцад эхийн хэвлийд байх үр хөврөл болон ураг гэмтэж бэртэх болон амь насаа алдсан тохиолдлыг хууль ёсны хохирогч хэмээн хүлээн зөвшөөрдөг. Тус хуульд эхийн хэвлийд(умайд) байгаа хүүхэд гэдгийг “хөгжлийн аль ч үе шатанд байгаа хомо сапиенсийн төрөл зүйлийн гишүүн, эхийн хэвлийд байгаа хүүхэд” гэж тодорхойлсон⁶⁸. Мөн үүнээс гадна Оросын холбооны улсын 1995 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан “Гэр бүлийн тухай” хуульд зааснаар үр хөврөл нь хүүхдийн адил эрх эдлэх⁶⁹ талаар, Холбооны бүгд найрамдах Герман улсын 1990 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Үр хөврөлийг хамгаалах тухай” гэх нэртэй актаар үр хөврөлийг устгахыг,

64 *Webster's new world medical dictionary*, (3rd ed. 2008), p. 275, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

65 Dr. Harvey Marcovitch, *Black's medical dictionary*, (41st ed. 2005), p. 229, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

66 *Webster's new world medical dictionary*, (3rd ed. 2008), p.138, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

67 *Embryo vs. Fetus: Differences Between Stages Week by Week*, Холбоос: https://www.medicinenet.com/em_bryo_vs_fetus_differences_week-by-week/article.htm, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

68 *Text of Unborn Victims of Violence Act Archived 2012-01-06 at the Wayback Machine*, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

69 The family code of the russian federation, Холбоос: <http://www.jafbase.fr/docEstEurope/RussianFamilyCode1995.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

шилжүүлэхийг гэмт хэрэг болгон хуульчлах⁷⁰ талаар тус тус хуульчилсан байна.

Монгол Улсад 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн Эрүүл мэндийн сайдын А/387 тоот тушаалаар батлагдсан “Үр хөндөлтийг зохицуулах журам”-аар үр хөврөл болон ургийн хоорондын ялгааг 1.1-т “Эрт үеийн үр хөндөлт” гэж жирэмсний эхний 12 долоо хоногийн дотор үр хөврөлийг умайгаас эмнэлгийн аргаар хийнэ”, 1.2-т “Хожуу үеийн үр хөндөлт” гэж жирэмсний эхний 13 долоо хоногоос 21 долоо хоногийн дотор жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслахыг хэлнэ” гэж тус тусад нь хугацаагаар тодорхойлсон байна. Үүнээс өөрөөр ураг ба үр хөврөлийн талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй юм.

Харин Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Гэмтлийн зэрэг тогтоох журам”-ын 3.5.3-т “жирэмслэлт таслагдах Үүнд: гэмтлийн улмаас жирэмслэлтийн хугацаанаас үл хамааран дутуу төрөх, ураг зулбах, ураг амьгүй болох тохиолдол хамаарна.” гэж зааснаар үр хөврөлийг устгасан тохиолдолд гэмтлийн хүнд зэрэгт хамаарч улмаар ураг зулбасан биш хүнд гэмтэл учирсан байхаар ойлгогдохоор байна.

Тиймээс “Ураг зулбах” болон “ураг” гэдэг нэр томьёог зөвхөн ураг буюу фетус гэх ойлголтын зүгээс тодорхойлох нь үр хөврөл буюу эмбрионыг эрх зүйн хамгаалалтаас гаргаж байгаа хэлбэр юм. Тиймээс Эрүүгийн хуульд тухайн ойлголтыг илүү өргөн утгаар ойлгосноор эмбрион буюу үр хөврөлийн шатанд байгаа хүүхдийг хамгаалах, эхийн эрх, ашгийг хамгаалах ач холбогдолтой. Ингэхдээ “жирэмслэлтийн хугацаанаас үл хамааран ураг зулбах” эсвэл “үр хөврөл болон ураг зулбасан” гэж томьёолох нь зүйтэй.

4.4. “Хууль бусаар үр хөндөх” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 15.5 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт тус тус тусгагдсан байна. Дээрх нэр томьёог тайлбарлахын тулд эхлээд “үр хөндөх” гэх ойлголтыг тодорхойлох нь зүйтэй.

“Үр хөндөх” гэдэг нь анагаахын шинжлэх ухааны ойлголт юм. Анагаахын шинжлэх ухаанд “үр хөндөх”-ийг жирэмсний 28 долоо хоногийн дотор жирэмслэлтийг таслан зогсоож, ургийг авах (ажилбар), аборт, жирэмснийг таслан зогсоох(уй)⁷¹ гэж тодорхойлсон байна. Мөн ураг хэвийн амьдрах чадвартай болохоос нь өмнө буюу жирэмсний 24 долоо хоногоос өмнө ургийг гадагшлуулахыг хэлнэ гэж тодорхойлдог. (Өнөө үед 22 долоо хоногтой ураг эсэн мэнд үлдсэн онцгой тохиолдол байдаг.) Үр хөндөлт нь ураг зулбалт болон эмнэлгийн үр хөндөлт гэсэн хоёр төрөлтэй байдаг. Ураг зулбалт нь жирэмслэлтийн 28 долоо хоногийн дотор тохиолддог бөгөөд нийт жирэмслэлтийн 25 хувь нь ураг зулбалтаар төгсдөг. Үүнээс 85 хувь нь жирэмсний 12 дахь долоо хоногийн дотор тохиолддог. Жирэмсний эхэн үед ураг зулбалт нь ургийн хромосомын эмгэгтэй ихэнхдээ холбоотой байдаг. Бусад шалтгааны хувьд умайн хэлбэр, чихрийн шижин, бамбай булчирхайн өвчин, дархлааны тогтолцооны асуудал зэрэг эхийн эмгэг зэрэг хамаарна. Эмнэлгийн үр

70 Act for Protection of Embryos, Холбооц: https://www.rki.de/SharedDocs/Gesetzestexte/Embryonenschutzgesetz_englisch.pdf?__blob=publicationFile, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

71 П.Нямдаваа, Н.Наранбаатар, Н.Наранбат, Н.Наранболд нар, *Анагаах ухааны нэр томьёоны товч тайлбар толь*, (УБ, 2006), 108 дахь тал.

хөндөлт гэдэг нь ерөнхийдөө хууль ёсны байдлаар эмнэлгийн нөхцөлд үр хөндөх юм. 1990 онд жирэмсэн үеийн үр хөндөлтийг заавал 24 дэх долоо хоногоос өмнө байх ёстойг Их Британи улсын холбогдох хуульд өөрчлөлт оруулж нэмсэн байна. Одоогийн байдлаар тус хуулиар жирэмслэлтийг үргэлжлүүлэх нь эмэгтэйн амь нас, эсвэл түүний одоо байгаа хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд эрсдэлтэй, эсвэл нялх хүүхдэд ноцтой гэмтэл учруулах эрсдэлтэй тохиолдолд үр хөндөлтийг хуулийн дагуу хийж болно. Их Британид эмнэлгийн үр хөндөлтийн 95 хувийг «эмэгтэйн бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндэд гэмтэл учруулах эрсдэлтэй» гэх үндэслэлээр явагддаг байна. Эхийн амийг аврах, ургийн ноцтой согог, эсвэл эхийн эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах эрсдэл ихтэй байдаг учраас энэхүү үндэслэлүүдээр эмнэлгийн үр хөндөлтийг зөвшөөрдөг. Түүнчлэн үр хөндөлтийг хийх аргын тухайд бүх үр хөндөлтийг тусгай зөвшөөрөлтэй эмнэлэгт эсвэл улсын эмнэлгүүдэд хийх ёстой байдаг ба эмийн болон мэс заслын аргаар хийдэг байна. Эмийн аргаар гэдэг нь Мифепристон ба простагландин (эсвэл простагландинтай төстэй эм, мисопростол) гэсэн хоёр эмийг хослуулан жирэмслэлтийг 63 хоног хүртэл хугацаанд тасалдуулахыг хэлдэг. Мэс заслын арга нь вакуум соруулагчаар соруулах арга байдаг ба жирэмсний 14-15 дахь долоо хоногт энэхүү аргыг хэрэглэдэг. Зарим маш туршлагатай эмэгтэйчүүдийн эмч нар жирэмсний 22 долоо хоног хүртэл умайн хүзүүг тэлэх, умайн агуулгыг нүүлгэн шилжүүлэх замаар үр хөндөлтийг мэс заслын аргаар хийдэг⁷².

Мөн үр хөндөх гэдгийг ураг амьдрах чадварын үе шатанд хүрэхээс өмнө умайгаас гадагшлуулах (хүний хувьд ихэвчлэн жирэмсний 20 дахь долоо хоног)⁷³ гэж нийтлэг байдлаар тодорхойлсон байна. Хууль зүйн нэр томъёоны тайлбарын хувьд үр хөндөлт болон үр зулбалт гэх нэр томъёогоор тодорхойлсон байна. Ингэж тодорхойлохдоо эхийн хэвлийд байгаа амьд ургийг үрийг 28 долоо хоног болохоос өмнө зулбах замаар жирэмслэлтийг зохиомлоор зогсоох⁷⁴ гэж тайлбарласан.

Дээрхээс дүгнэвэл жирэмслэлтийн 28 дахь долоо хоногийн дотор ургийг хүчээр гадагшлуулж, жирэмслэлтийг таслан зогсоох үйл явц болох нь харагдаж байна. 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/387 дугаартай Эрүүл мэндийн сайдын тушаалаар Монгол Улсад үр хөндөлттэй холбоотой журмыг “Үр хөндөлтийг зохицуулах журам” нэртэйгээр баталсан. Энэхүү журам нь 2011 оны 5 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан “Эрүүл мэндийн тухай хууль”-ийн 32.3-т заасан үр хөндөх ажилбар гүйцэтгэх журам юм. Тиймээс тус журмаар үр хөндөх нь хууль ёсны үр хөндөлт бөгөөд үүнд нийцээгүй үр хөндөлт нь хууль бус үр хөндөлт болно. Тус журмаар үр хөндөлтийг эрт үеийн болон хожуу үеийн гэж ангилан түүнд тавигдах шаардлагыг хуульчилсан.

Эрт үеийн үр хөндөлт

Эрт үеийн үр хөндөлт гэж жирэмсний эхний 12⁶ долоо хоногийн дотор үр хөврөлийг умайгаас эмнэлгийн аргаар гаргахыг хэлнэ.

Эрт үеийн үр хөндөлтийг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн журам, зааврын шаардлагыг хангасан, гарч болох хүндрэлээс сэргийлэх, эмчлэх бэлтгэлийг

72 Dr. Harvey Marcovitch, *Black's medical dictionary*, (41st ed. 2005), p.4.

73 *Britannica:Abortion*, Холбоос: <https://www.britannica.com/science/abortion-pregnancy>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

74 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (УБ, 2007), 489 дэх тал.

бүрэн хангасан, хүндрэлээс сэргийлэх, хүндрэл гарсан тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх бэлтгэл бүрэн хангагдсан, 24 цагаар үйлчилгээ үзүүлдэг “Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах” тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг, клиник, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн сум дундын эмнэлэгт, эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээтэй эмч үр хөндөхийг зөвшөөрнө.

Эрт үеийн үр хөндөлтийг эмэгтэйн өөрийнх нь хүсэлтээр төлбөртэйгээр, эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр төлбөргүйгээр холбогдох шинжилгээг бүрдүүлж, зөвхөн эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмч гүйцэтгэнэ.

Хожуу үеийн үр хөндөлт

Хожуу үеийн үр хөндөлт гэж жирэмсний 13 долоо хоногоос 21⁺⁶ долоо хоногийн дотор жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслахыг хэлнэ.

Хожуу үеийн үр хөндөлтийг мэргэжлийн эмч нарын дүгнэлт, зөвлөгөөний шийдвэрээр дор дурдсан заалтаар зөвхөн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Амаржих газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээтэй эм үр хөндөх ажилбарыг хийнэ. Үүнд:

- Тухайн жирэмслэлт нь эхийн амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон;
- Ургийн эмгэг нь амьдралд үл нийцэх гажиг болох нь тогтоогдсон;
- 18 хүртэлх насны охид өөрөө хүсвэл эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр;
- 40-өөс дээш насны эмэгтэй өөрөө хүсвэл;
- Цусан төрөл ойртсон нь нотлогдсон;
- Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн.

Дээр дурдсан заалтуудаас бусад тохиолдолд жирэмснийг хожуу хугацаанд таслахыг хориглоно.

Дараах тохиолдолд үр хөндөхийг түр хойшлуулж, холбогдох эмчилгээг хийсний дараа үр хөндөх ажилбарыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Эрхтэн тогтолцооны цочмог үрэвсэл болон архаг үрэвсэлт өвчний сэдрэлттэй;
- Бөөр шээсний зам болон бэлэг эрхтний хурц үрэвсэл оношлогдсон бол.

Үр хөндөх ажилбар хийсэн эмч тухайн ажилбарын талаар “Үр хөндөлт”-ийн түүхэнд тэмдэглэж, үр хөндөлтийн бүртгэлийн маягтад бүртгэнэ.

Эрт үеийн үр хөндөлт хийхийн өмнө эмэгтэйд үр хөндөлтийн талаар таниулж, сонгосон аргаар үр хөндүүлэх зөвшөөрлийг бичгээр авч, “Үр хөндөлт”-ийн түүхэнд хавсаргана.

Хожуу үед үр хөндөхөд дараах баримт бичгийг бүрдүүлж, “Үр хөндөлт”-ийн түүхэнд хавсаргана. Үүнд:

- Эмч нарын зөвлөгөөний шийдвэр;

- Үр хөндүүлэх эмэгтэйн өөрийнх нь, 18 хүртэлх насны охидын эцэг, эх, асран хамгаалагчийн, иргэний эрх зүйн чадамжгүй сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийг бичгээр авсан байна;
- Хэрвээ бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн тохиолдолд хууль, хяналтын байгууллагын тодорхойлолт;
- Цусан төрөл ойртсон нь нотлогдсон хууль, хяналтын байгууллагын тодорхойлолт.

Үр хөндөлтийн дараа гарч болох хүндрэл, жирэмслэхээс сэргийлэх үр дүнтэй аргын талаар зөвлөгөөг үйлчлүүлэгчид өгч, энэ тухай “Үр хөндөлт”-ийн түүхэнд тэмдэглэнэ.

Эрүүл мэндийн статистик мэдээлэл хариуцсан эмч үр хөндөлтийн тухай тайланг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 тоот тушаалын ЭМТ-201.12 батлагдсан маягтын дагуу нэгтгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн мэдээллийн албанд мэдээллэнэ.

4.5. “Хөгжлийн бэрхшээлтэй” гэх нэр томъёоны тухайд.

Тус нэр томъёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 11.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 13.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийг Улсын Их Хурлаас баталсан байна. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдгийг бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүн гэж тайлбарласан.

Мөн «Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай» конвенцийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2006 оны 12 дугаар сард баталсан ба тус олон улсын гэрээг Монгол Улс 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр соёрхон баталсан байна. Энэхүү конвенцын зорилготой холбоотой хэсэг буюу 1 дүгээр зүйлд “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдгийг бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ гэсэн бөгөөд мөн “хөгжлийн бэрхшээл” гэдгийг өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт, нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн чөлөөтэй оролцоход саад тотгор учруулахуйц бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх⁷⁵ гэж тус тус тодорхойлжээ.

Хууль зүйн толь бичигт тус нэр томъёог “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн” буюу латинаар *invalidus*, англиар *disability*, оросоор *инвалидность* гэж тодорхойлон төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавх нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс

⁷⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, Холбоос: <https://mlsp.gov.mn/uploads/files/186924b7c9448142182ac9ad7d5598b4187d7c00.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүн⁷⁶ гэж тодорхойлсон байна.

Судлаачид энэхүү нэр томьёог янз бүрээр судалдаг бөгөөд хамгийн сүүлийн үеийн судалгаагаар эмнэлгийн нэр томьёонд хамаатуулж судалсан байна. Тус судалгаагаар “Хөгжлийн бэрхшээл хүний ердийн хийж гүйцэтгэдэг үйл ажиллагаа эсхүл ердийн гэж үзэх үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд саад болох аливаа хязгаарлалт, эсхүл гүйцэтгэх чадваргүй (согогийн улмаас) байх”-ыг хэлнэ⁷⁷ гэж үзээд өөрөөр хэлбэл үүнд тахир дутуу гэх ойлголт хамаардаг гэж авч үзсэн. Тахир дутуу гэдгийг “өвчин эмгэг, гэмтлийн улмаас хүний бие махбодын үйл ажиллагаа удаан хугацаагаар буюу бүрэн алдагдах. Тахир дутуу болох гэдэгт осол гэмтэл, архаг өвчнөөр өвчилсний улмаас юмуу, бие эрхтний үйл ажиллагаа гэмтэж байнга, эсвэл удаан хугацаагаар тодорхой мэргэжлийн ажил хийх чадвараа бүрэн буюу түр алдахыг хэлнэ. Төрөлхийн гажиг, бие эрхтний дутуу хөгжил, эрхтний согог үүнд орно. Монголд хөдөлмөрийн чадвар алдсан хэмжээнээс хамаарч тахир дутуугийн зэрэг тогтоодог. Тахир дутуу болоход улсаас тэтгэвэр өгөхөөс гадна захиргаа, ажлын газар нь тахир дутуу хүмүүст тохирсон үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох, тэдний ажлын цагийг хорогдуулах, гэрээр ажиллуулах зэргээр хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөх, халамж үзүүлэх үүрэгтэй”⁷⁸ гэж тайлбарласан байна. Хөгжлийн бэрхшээл гэх ойлголтыг нэг мөр болгож, тайлбарт тахир дутуугийн ойлголтыг оруулж өгөх хэрэгтэй⁷⁹ гэж тодорхойлж саналыг өгсөн байна.

Тиймээс дээрхээс дүгнэвэл анагаахын шинжлэх ухааны зүгээс болон хууль зүйн талаас тахир дутуугийн ойлголт хамаарах эсэхийг шийдвэрлэн нэг мөр тодорхойлолтыг бий болгох хэрэгтэй байна.

Тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй, саад бэрхшээлтэй гэх нэр томьёо боловсролын түвшинд, зөвлөгөөнд, эрүүл мэндийн номонд ижил утгаар хэрэглэгддэг. Хэдийгээр эдгээр гурван нэр томьёогоор тус бүр хөгжлийн бэрхшээлтэй болох нөхцөл байдлыг илэрхийлдэг ч гурван өөр утгаар ойлгогддог. Эдгээр нэр томьёоны зохистой хэрэглээг дэмжихийн тулд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй, саад бэрхшээлтэй гэх олон улсын ангилалд (1980) дараах тодорхойлолтыг өгсөн болно.

Тахир дутуу (Impairment) - Сэтгэл зүй, физиологи, анатомийн бүтэц, үйл ажиллагааны алдагдал, хэвийн бус байдал. (Тэмдэглэл: Тахир дутуу гэдэг нь өвчин гэхээс илүүтэйгээр гадна талын бүрэн бүтэн байдал алдагдах явдал юм. Жишээлбэл хөлөө алдах нь тахир дутуу болж байгаагийн шинж бөгөөд өвчин биш юм.)

Хөгжлийн бэрхшээлтэй (disability) - Хүний хувьд хэвийн гэж тооцогдох байдлаар эсвэл тус хүрээнд үйл ажиллагаа явуулахад саад болох аливаа хязгаарлалт, чадварын дутагдалтай байдал.

76 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (УБ, 2007), 523 дахь тал.

77 Ц.Лхагвасүрэн нар, *Монголын Анагаахын үндэсний нээтэрхий толь. III боть*, (УБ, 2012), 1569 дэх тал.

78 Я.Жамбалдорж, *Анагаах ухааны танин мэдэхүйн толь*, (УБ, 2009), 413 дахь тал.

79 П.Ариунболд, М.Цэрэнбат, Ж.Эрдэнэбулган, *2002 ба 2015 оны Эрүүгийн хууль дахь эмнэлгийн нэр томьёоны харьцуулалт*, Гэмт явдалтай тэмцэх асуудал №1 (2019), 79 дэх тал.

Саад бэрхшээлтэй (Handicap) - Тахир дутуу хүн амьдралынхаа хэвийн үүргээ бүрэн биелүүлж чадахгүй байгаагийн үр дүн⁸⁰.

Мөн үүнээс гадна тухайн ойлголтуудын шинж чанаруудыг тус бүрт нь тодорхойлсон байна.

Тахир дутуу (Impairment) - Сэтгэцийн үйл ажиллагааны тогтолцоог оролцуулан мөч, эрхтэн, эд эс болон биеийн бусад бүтцэд гажиг, согог, гэмтэл байгаа эсвэл тохиолдсоныг багтаасан түр зуурын эсвэл байнгын байж болох алдагдал, хэвийн бус байдлаар тодорхойлогддог. Энэ нь эмгэгийн төлөв байдлын гаднах байдлыг илэрхийлдэг бөгөөд зарчмын хувьд энэ нь эрхтний түвшний эмгэгийг илэрхийлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй (disability) - Хөгжлийн бэрхшээлтэй байдал нь ердийн хүлээгдэж буй үйл ажиллагааны гүйцэтгэл, зан үйлийн илүүдэл эсвэл дутагдлаар тодорхойлогддог бөгөөд эдгээр нь түр зуурын эсвэл байнгын, эргэлт буцалтгүй эсвэл өөрчлөгдөмтгий, дэвшилттэй эсвэл бууралттай байж болно. Хөгжлийн бэрхшээл нь тахир дутуу байдлын шууд үр дагавар эсвэл хувь хүний, ялангуяа сэтгэл зүйн, бие махбодын, мэдрэхүйн болон бусад согогийн хариу урвалын улмаас үүсч болно. Хөгжлийн бэрхшээлтэй байдал нь тахир дутуу байдлыг бодит байдлаар илэрхийлдэг бөгөөд хүний өдөр тутмын амьдралын чухал бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрөгдсөн нийлмэл үйл ажиллагаа, зан үйлийн хэлбэрт хөгжлийн бэрхшээлийн түвшингөөс хамаарч саад учруулах үзэгдэл юм. Жишээлбэл, биеэ зөв авч явах, өөртөө анхаарал тавьхад хамаарах хязгаарлалтууд (шээс ялгаруулалтыг хянах, өөрийгөө угаах, хооллох чадвар гэх мэт), өдөр тутмын амьдралын бусад үйл ажиллагаа, хөдөлгөөний үйл ажиллагаа (алхах чадвар гэх мэт) гэх зэрэг орно.

Саад бэрхшээлтэй (Handicap) - Саад бэрхшээлтэй гэдэг нь тухайн хүний нөхцөл байдал, туршлага нь хэвийн байдлаас гажсан тохиолдолд түүнд хамаарах утга учрыг харуулж байдаг. Энэ нь тухайн хүний үзүүлэлт, байр суурь болон тухайн хүний өөрийн эсвэл бусдын гишүүн болсон бүлгийн хүлээлт хоорондын зөрүүгээр тодорхойлогддог. Тиймээс саад бэрхшээлтэй байдал нь тахир дутуу байдал болон хөгжлийн бэрхшээлийн нийгэмшүүлэх асуудлыг илэрхийлдэг бөгөөд тахир дутуу байдал болон хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй хувь хүн-соёл, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр дагаврыг тусгадаг. Сул тал нь бүтэлгүйтэл, чадваргүй байдлаас хувь хүний орчлон ертөнцийн хүлээлт, хэвийн байдалд нийцэхгүй байхаас үүсдэг. Тиймээс “амьд үлдэх үүрэг” гэж тодорхойлж болох зүйлийг тогтвортой байлгах чадварт саад учруулах үед саад бэрхшээлтэй байдал үүсдэг⁸¹.

Эдгээр тодорхойлолтууд дээр үндэслэн саад бэрхшээл нь тухайн хүний шинж чанар биш, харин хүн ба хүрээлэн буй орчны хоорондын харилцааны тодорхойлолт гэдгийг ойлгох хэрэгтэй. Дараах жишээгээр ойлгох нь зүйтэй. Төрөлхийн хараагүй (тахир дутуу) хүн хэвлэмэл материалыг унших чадваргүй байдаг. Хэвлэмэл материал нь ихэнх мэдээллийг олон нийтэд түгээдэг байна (хөгжлийн бэрхшээл). Хэрэв энэ хүнд тахир дутуу, хөгжлийн бэрхшээлийн улмаас сургуульд сурах, ажилд ороход саад болсон бол энэ нь саад бэрхшээл болно. Энэ хүн энэ бэрхшээлийг даван туулахын тулд зарим төрлийн туслах технологийг ашиглан өдөр тутмын үйл

80 *International classification of impairments, disabilities, and handicaps : a manual of classification relating to the consequences of disease, published in accordance with resolution WHA29.35 of the Twenty-ninth World Health Assembly, May 1976*

81 Мөн тэнд.

ажиллагаагаа (унших) хийх боломжтой байж болно. Саад бэрхшээлийг хувь хүнээс илүүтэй хүрээлэн буй орчинтой холбон тайлбарласнаар функциональ хязгаарлалт дээр анхаарлаа төвлөрүүлэхийн оронд үйл ажиллагааны үр дүнд хүрэхийн тулд технологийг ашиглахад онцгой анхаарал хандуулдаг⁸².

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 1976 оны 5-р сарын Дэлхийн эрүүл мэндийн хорин есдүгээр ассамблейн хурлаар “Тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй, саад бэрхшээлтэй гэх ойлголтын олон улсын ангилал: Өвчний үр дагавартай холбоотой ангиллын гарын авлага” гэх нэртэй ангилал нь WHA29 тогтоолын дагуу нийтлэгдсэн. Тус ангиллаар тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй, саад бэрхшээлтэй гэх ангилалд хамаарах ойлголтуудыг дараах байдлаар тодорхойлсон.

Тахир дутуу (Impairment) гэх ойлголт нь ангиллын хувьд дараах ангиллуудад хуваагдсан байна. Үүнд:

1. Оюуны хомсдол
2. Бусад сэтгэхүйн тахир дутуу байдал
3. Хэлний тахир дутуу байдал
4. Сонсголын тахир дутуу байдал
5. Харааны тахир дутуу байдал
6. Дотоод эрхтний тахир дутуу байдал
7. Араг ясны тахир дутуу байдал
8. Хэлбэр дүрсээ алдсан тахир дутуу байдал
9. Ерөнхий, мэдрэмжийн болон бусад тахир дутуу байдал

Харин хөгжлийн бэрхшээлтэй (disability) гэх ойлголт нь дараах ангиллуудад хуваагддаг байна. Үүнд:

1. Зан үйлийн хөгжлийн бэрхшээлтэй
2. Харилцаа холбооны хөгжлийн бэрхшээлтэй
3. Хувийн амьдралдаа анхаарал тавих хөгжлийн бэрхшээлтэй
4. Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй
5. Биеийн байдлын хөгжлийн бэрхшээлтэй
6. Сэтгэн бодох чадварын хөгжлийн бэрхшээлтэй
7. Нөхцөл байдлын хөгжлийн бэрхшээлтэй
8. Тодорхой чадварын хөгжлийн бэрхшээлтэй
9. Бусад үйл ажиллагааны хязгаарлалт

Саад бэрхшээлтэй байдлын ангилал нь сул дорой байдлын ангилал биш, хувь хүмүүсийн ангилал ч биш гэдгийг ойлгох нь чухал юм. Харин энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиолдож болох нөхцөл байдлын ангилал бөгөөд нийгмийн хэм хэмжээний хувьд ийм хүмүүс үе тэнгийнхнээсээ сул дорой байдалд оруулдаг нөхцөл байдал юм. Үүнд:

1. Чиг хандлагын саад бэрхшээлтэй
2. Бие махбодын бие даасан байдлын саад бэрхшээлтэй
3. Хөдөлгөөний саад бэрхшээлтэй
4. Ажил мэргэжлийн саад бэрхшээлтэй
5. Нийгмийн хамтарсан саад бэрхшээлтэй

82 *Lowa center for Assistive Technology Education and Research: Module 1 - Conceptualizing Disability*, Холбоос: https://www.continuetolearn.uiowa.edu/nas1/07c187/Module%201/module_1_p3.html, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

6. Эдийн засгийн өөр өөрийгөө хангах саад бэрхшээлтэй

7. Бусад саад бэрхшээлтэй⁸³

2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-т хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах шалгуураар тогтоохоор хуульчилсан байна. Үүнд:

-Эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, ангилал, хугацаа

-Биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын ангилал

Тиймээс дээрх ангилал нь Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тодорхойлох шаардлагын нэг нь болж байна.

Мөн тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-т комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлэхээр зохицуулагдсан байна. Өнөөгийн байдлаар буюу 2021 онд нийт Монгол Улсад 106169 хөгжлийн бэрхшээлтэй хүн бүртгэгдсэн байна. Үүнээс харааны хөгжлийн бэрхшээлтэй хүн 11695, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн 20414, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн 4074, хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүн 21011, сонсголын хөгжлийн бэрхшээлтэй хүн 8430, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүн 7430, бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн 33115 тус тус бүртгэгдсэн байна⁸⁴.

Эцэст нь дүгнэвэл хөгжлийн бэрхшээлтэй гэх ойлголт нь тахир дутуу (Impairment), саад бэрхшээлтэй (Handicap) гэх ойлголтоос тусдаа ойлголт бөгөөд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад тухайн ойлголтыг конвенцийн дагуу зөв тодорхойлж бүртгэлжүүлэх ажлыг хийсэн болох нь харагдаж байна. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүний ангиллын зарим хэсгийг явцуу хүрээнд тодорхойлж, бүртгээгүй орхисон байна. Тухайлбал, Монгол Улсад тодорхойлсон хараа, хэл яриа, сонсголын хөгжлийн бэрхшээл нь нийтдээ харилцаа холбооны хөгжлийн бэрхшээлд хамаарахаар байна. Мөн зан үйлийн хөгжлийн бэрхшээл, хувийн амьдралдаа анхаарал тавих хөгжлийн бэрхшээл, биеийн байдлын хөгжлийн бэрхшээл, нөхцөл байдлын хөгжлийн бэрхшээл, тодорхой чадварын хөгжлийн бэрхшээл зэргийг тодорхойлж, бүртгээгүй орхисон байна. Тиймээс Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, бүртгэлийн тогтолцоонд тухайн тодорхойлолтыг тусгаж нэг мөр байдлаар ойлгох нь зүйтэй байна.

4.6. “Сэтгэл засал” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт тусгагдсан байна.

Эрүүгийн хуульд тус нэр томьёо нь тусгагдахдаа “Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, согтуурах, мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.” гэж зохицуулагдсан буюу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний нэг төрөл болон хуульчлагдсан

83 *International classification of impairments, disabilities, and handicaps : a manual of classification relating to the consequences of disease, published in accordance with resolution WHA29.35 of the Twenty-ninth World Health Assembly, May 1976*

84 *Статистикийн мэдээллийн нээгдсэн сан*, Холбоос: https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_976_976_L32&type=tables, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

байна. Эрүүл мэндийн сайдын А/512 тоот тушаалын хавсралтад “Сэтгэл засал гэж сэтгэцийн эмгэг /түгшүүр, сэтгэл гутрал, гэмтлийн дараах стрессээс үүдэлтэй эмгэг гэх мэт/ болон зан үйлийн эмгэг /түрэмгий байдал, цочмог зан, хор хохирол учруулах үйлдэл гэх мэт/-тэй хүмүүст ярилцлага болон бусад аргаар эмчилгээ хийхийг хэлнэ⁸⁵.” гэж тодорхойлсон байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 12-ны А/394 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”-ын 1.2 дахь хэсэгт сэтгэл зүйн цочмог хариу урвалууд илэрсэн, сэтгэц, зан үйлийн эмгэг /айдсын эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн, сэтгэл гутрах ба сэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, дасан зохицохуйн эмгэг, хувирах болон хуваагдах эмгэг, солиорох эмгэг/-т өртсөн хохирогчид сэтгэл заслын тусламж, үйлчилгээг үзүүлнэ гэж тодорхойлогдсон байна.

Мөн сурах бичигт сэтгэл засал гэдгийг сэтгэл зүйн онол ба аргуудад үндэслэж, үйлчлүүлэгчид сэтгэлийн түгшүүр төрүүлдэг мэдрэмж, сэтгэгдэл, харилцаа, сэтгэл зүйн шинж тэмдгүүдийг арилгах явдлыг зохицуулахаар хувь хүн ба бүлэгт тусламж үзүүлэх системтэй, чиглэл зорилго бүхий ажиллагаа юм гэж тодорхойлсон.⁸⁶

Олон улсын нэвтэрхий тольд сэтгэл засал гэдгийг “Сэтгэл заслын эмчилгээ, зөвлөгөө гэж нэрлэдэг ба сэтгэл зүй, сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийг эмчлэх аливаа хэлбэрийн эмчилгээ бөгөөд үүнд бэлтгэгдсэн хүн шинж тэмдгүүдийг өөрчлөх, арилгах, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор нэг буюу хэд хэдэн өвчтөнтэй харилцаа тогтоох юм.”⁸⁷ гэж тодорхойлсон байна.

Монголын Анагаах ухааны үндэсний нэвтэрхий тольд “Сэтгэл засал (Psychotherapy) сэтгэл зүйн аргуудын тусламжтайгаар сэтгэл зүйн гаралтай бие махбодын эмгэгүүдийг эмчлэхийг сэтгэл засал гэнэ” гэж тодорхойлсон байна. Түүнчлэн сэтгэл засал буюу психотерапиг өөр толь бичигт “үг яриа болон үйлдлээр сэтгэцэд нөлөөлж төрөл бүрийн өвчин, эмгэгийг анагаах арга⁸⁸” гэж тодорхойлсон байна. Харин олон улсын анагаахын толь бичигт сэтгэл засал гэдгийг дараах байдлаар тайлбарласан байна.

“Сэтгэл зүйн болон сэтгэцийн эмгэгийг эмчлэх бие махбодын бус сэтгэлзүйн арга. Зарим өвчин, зарим зан байдлын хувьд сэтгэцийн хүчин зүйл бусадтай харьцуулахад илүү тод илэрдэг. Ийм тохиолдлуудад сэтгэл заслын эмчилгээ онцгой чухал байдаг. Ашиглаж буй үндсэн аргууд нь үйлчлүүлэгч болон сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэгч хоёрын хоорондын харилцаатай хамгийн чухал хамааралтай байдаг.”⁸⁹

Тухайн тодорхойлолтоос үзэхэд сэтгэл заслын эмчилгээ нь сэтгэл зүйн болон сэтгэцийн эмгэгийг болон түүнийг эмчлэх эмчилгээний аргыг тодорхойлох нь зүйтэй байна.

85 П.Ариунболд, М.Цэрэнбат, Ж.Эрдэнэбулган, 2002 ба 2015 оны Эрүүгийн хууль дахь эмнэлгийн нэр томъёоны харьцуулалт, Гэмт явдалтай тэмцэх асуудал №1 (2019), 81 дэх тал.

86 Г.Гантөмөр, С.Гантулга, Б.Энхболд, Л.Бат-Очир, Ж.Төгс-Очир, Эрүүгийн эрх зүйн Ерөнхий анги сурах бичиг, (УБ, 2020), 430 дахь тал.

87 Britannica: Psychotherapy, Холбоос: <https://www.britannica.com/science/psychotherapy>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

88 П.Нямдаваа, Н.Наранбаатар, Н.Наранбат, Н.Наранболд, Анагаах ухааны нэр томъёоны товч тайлбар толь, (УБ, 2006), 75 дахь тал.

89 Dr. Harvey Marcovitch, *Black's medical dictionary*, (41st ed. 2005), p.593.

Сэтгэл зүй гэдгийг тайлбар тольд “Хүмүүсийн хэрхэн бодож, хэрхэн, яагаад үйлдэл, хариу үйлдэл, харилцан үйлчлэл үзүүлж байгааг судалдаг шинжлэх ухаан юм. Энэ нь ой санамж, оновчтой ба иррационал сэтгэлгээ, оюун ухаан, суралцах чадвар, зан чанар, ойлголт, сэтгэл хөдлөл зэрэг асуудлуудыг хамардаг⁹⁰.” гэж тодорхойлсон бөгөөд сэтгэл зүйн эмгэг гэдгийг “Амьдралын олон талбарт нөлөөлдөг зан үйл эсвэл сэтгэлзүйн шинж тэмдгүүдийн нийлбэр юм. Эдгээр эмгэгүүд нь шинж тэмдгийг тухайн хүнд мэдрүүлж сэтгэлийн зовиур үүсгэдэг⁹¹.” байна. Харин сэтгэцийн эмгэг гэдгийг “Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтний оношилсон сэтгэцийн эмгэг бөгөөд таны сэтгэхүй, сэтгэл санаа болон/эсвэл зан үйлийг ихээхэн алдагдуулж, тахир дутуу болох, өвдөх, үхэх, эрх чөлөөгөө алдах эрсдэлийг ноцтой нэмэгдүүлдэг⁹².” гэж тайлбарласан байна.

Сэтгэл зүйн эмгэг гэдэгт дараах өвчнүүдийг хамааруулж ойлгохоор байна. Үүнд:

-Мэдрэлийн хөгжлийн эмгэгүүд:

- Оюуны хөгжлийн эмгэг;
- Хөгжлийн саатал;
- Харилцааны эмгэг;
- Аутизмын спектрийн эмгэг;
- Анхаарал хомсдолын хэт идэвхжилийн эмгэг (ADHD).

-Хоёр туйлт ба түүнтэй холбоотой эмгэгүүд:

- Маниа;
- Сэтгэл гутралын үеүүд.

-Сэтгэлийн түгшүүрийн эмгэгүүд:

- Ерөнхий түгшүүрийн эмгэг (GAD);
- Нийгмийн түгшүүрийн эмгэг;
- Тусгайлсан фобиа;
- Паниктай холбоотой эмгэг;
- Салах айдсын түгшүүр.

-Траума болон стресстэй холбоотой эмгэг:

- Цочмог стрессийн эмгэг;
- Зохицуулалтын эмгэг;
- Трауманы дараах стрессийн эмгэг (PTSD);
- Сэтгэл хөдлөлийн хам эмгэг.

-Тусгаарлалтын эмгэг:

- Тусгаарлалтын ой тогтоолтын гажиг;
- Тусгаарлалтын танихтай холбоотой эмгэг;
- Хувь хүнийг үгүйсгэх, бодит байдлыг үгүйсгэх эмгэг.

90 Dr. Harvey Marcovitch, *Black's medical dictionary*, (41st ed. 2005), p.592.

91 A List of Psychological Disorders, Холбоос: <https://www.verywellmind.com/a-list-of-psychological-disorders-2794776#:~:text=The%20term%20psychological%20disorders%20is,the%20person%20experiencing%20the%20symptoms>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

92 American Psychological Association. Mental disorder.

-Соматик шинж тэмдэгтэй эмгэгүүд:

- Соматик шинж тэмдэгтэй эмгэг;
- Өвчинтэй холбоотой санаа зовнилын эмгэг;
- Хувиргалтын эмгэг;
- Дуураймал эмгэг.

-Тэжээх болон хооллох эмгэгүүд

- Хоолны дуршилгүй болох эмгэг;
- Цадхаа мэдэхгүй идэх эмгэг;
- Зажлах эмгэг;
- Хоол биш зүйлийг идэх эмгэг;
- Хэт их идэх эмгэг.

-Унтах сэрэхтэй холбоотой эмгэг:

- Маш их унтах мэдрэмжийг өгөх эмгэг;
- Нойргүйдлийн эмгэг;
- Нойрмог байдлын эмгэг;
- Амьсгалахтай холбоотой нойрны эмгэг;
- Парасомния;
- Хөл амрахгүй байх эмгэг.

-Эмх замбараагүй байдал, өөрийгөө хянах байдал, зан байдлын эмгэгүүд:

- Клептоманиа (Өөрийгөө удирдаж чадахгүй бусдын эд зүйлийг хулгайлах эмгэг);
- Пироманиа (Өөрийгөө удирдаж чадахгүй бусдыг болон өөрийгөө буудах эмгэг);
- Үе үе тэсэрч хэт их уурлах эмгэг;
- Зан байдлын эмгэг;
- Ичгүүргүй байдлын эмгэг.

-Сэтгэл гутралын эмгэгүүд:

- Сэтгэлийн хямралыг зохицуулах эмгэг;
- Голлох сэтгэл гутралын эмгэг;
- Байнгын сэтгэл гутралын эмгэг;
- Бусад тодорхойлсон сэтгэл гутралын эмгэг;
- Сарын тэмдгийн өмнөх дисфорийн эмгэг;
- Бодис/эмээс үүдэлтэй сэтгэл гутралын эмгэг;
- Өөр нэг эмгэгийн улмаас үүссэн сэтгэлийн хямрал.

-Бодисын хэрэглээ ба донтох эмгэг:

- Согтууруулах ундаатай холбоотой эмгэгүүд;
- Каннабистай холбоотой эмгэгүүд;
- Хиймэл амьсгалтай холбоотой төхөөрөмжийн эмгэгүүд;
- Өдөөгч хэрэглэх эмгэг;
- Тамхи хэрэглэх эмгэг;
- Мөрийтэй тоглоомтой холбоотой эмгэг.

-Мэдрэлийн танин мэдэхүйн эмгэгүүд:

- Дэмийрэл;
- Мэдрэлийн танин мэдэхүйн бусад эмгэгүүд.

-Шизофрени спектр ба бусад сэтгэцийн эмгэгүүд:

- Хий юм төсөөлөх;
- Хий зүйл харах, сонсох;
- Эмх замбараагүй юм ярих.

-Донтолт-хүсэх болон түүнтэй холбоотой эмгэгүүд:

- Донтолт-хүсэлтийн эмгэг (OCD);
- Биеийн дисморфик эмгэг;
- Хуримтлуулах эмгэг;
- Трихотилломани (үс зулгаах эмгэг);
- Арьсаа хуулах эмгэг;
- Бодис, эмтэй холбоотой хамаарах эмгэгүүд;
- Бусад өөр эмгэгээс үүссэн донтох-хүсэх эмгэг.

-Зан чанарын эмгэгүүд:

- Нийгмийн эсрэг зан чанарын эмгэг;
- Зайлсхийх зан чанарын эмгэг;
- Завсрын зан чанарын эмгэг;
- Хамааралтай зан чанарын эмгэг;
- Жүжиглэх зан чанарын эмгэг;
- Өөрөөрөө бахарах зан чанарын эмгэг;
- Донтолт-хүсэлтийн зан чанарын эмгэг;
- Паранойд зан чанарын эмгэг;
- Шизоид зан чанарын эмгэг.⁹³

Харин сэтгэцийн эмгэг гэдэгт дараах өвчнийг хамааруулж ойлгохоор байна.

Үүнд:

- Мэдрэлийн хөгжлийн эмгэгүүд;
- Хоёр туйлт ба түүнтэй холбоотой эмгэгүүд;
- Сэтгэлийн түгшүүрийн эмгэгүүд;
- Траума болон стресстэй холбоотой эмгэг;
- Тусгаарлалтын эмгэг;
- Соматик шинж тэмдэгтэй эмгэгүүд;
- Тэжээх болон хооллох эмгэгүүд;
- Унтах сэрэхтэй холбоотой эмгэг;
- Эмх замбараагүй байдал, өөрийгөө хянах байдал, зан байдлын эмгэгүүд;
- Устгах эмгэгүүд;
- Сэтгэл гутралын эмгэгүүд;
- Бэлгийн үйл ажиллагааны алдагдал;
- Хүйсийн дисфори;
- Парафилик эмгэгүүд;

93 A List of Psychological Disorders, Холбооц: <https://www.verywellmind.com/a-list-of-psychological-disorders-2794776#:~:text=The%20term%20psychological%20disorders%20is.the%20person%20experiencing%20the%20symptoms>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

- Бодисын хэрэглээ ба донтох эмгэг;
- Шизофрени спектр ба бусад сэтгэцийн эмгэгүүд;
- Донтолт-хүсэх болон түүнтэй холбоотой эмгэгүүд;
- Зан чанарын эмгэгүүд.⁹⁴

Мөн сэтгэцийн эмгэг гэдгийг дотоодын эрх зүйн зохицуулалтад буюу 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуулийн 3.1.3-т өвчний олон улсын ангиллын “сэтгэц, зан үйлийн эмгэгүүд” бүлэгт заасан оношилгооны хэмжүүрээр оношилж болох бүх өвчнийг хэлнэ гэж тодорхойлсон байна. Үүнд дараах эмгэгүүд хамаардаг байна. Үүнд:

- F00-F09 Органик, түүний доторх шинж тэмдгийн сэтгэцийн эмгэгүүд;
- F10-F19 Сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэснээс үүдэлтэй сэтгэцийн болон зан үйлийн эмгэг;
- F20-F29 Шизофрени, шизотипийн болон дэмийрэлийн эмгэгүүд;
- F30-F39 Сэтгэл хөдлөлийн эмгэгүүд;
- F40-F48 Невротик, стресстэй холбоотой болон соматоформын эмгэгүүд;
- F50-F59 Физиологийн эмгэг, физик хүчин зүйлтэй холбоотой зан үйлийн синдромууд;
- F60-F69 Насанд хүрэгчдийн зан чанар, зан үйлийн эмгэг;
- F70-F79 Сэтгэцийн хомсдол;
- F80-F89 Сэтгэл зүйн хөгжлийн эмгэг;
- F90-F98 Зан төлөв, сэтгэл хөдлөлийн эмгэгүүд (ихэвчлэн хүүхэд, өсвөр насанд тохиолддог.);
- F99-F99 Тодорхойгүй сэтгэцийн эмгэг.⁹⁵

Дээрхээс дүгнэвэл сэтгэцийн эмгэг болон сэтгэл зүйн эмгэг нь ерөнхийдөө хоорондоо ижил, төстэй болох нь харагдаж байна. Тиймээс сэтгэл засал, сэтгэл заслын эмчилгээ нь тухайн эмгэгүүдийг эмчлэх зориулалттай байх нь тодорхой байна. Америкийн сэтгэл зүйн холбооноос тухайн эмгэгийг эмчлэх сэтгэл заслын дараах 5 ерөнхий эмчилгээ байгааг тодорхойлсон.

1. Психоанализ ба психодинамик эмчилгээ

Энэ арга нь асуудалтай зан байдал, мэдрэмж, бодлыг тэдний ухамсаргүй утга учир, сэдлийг олж илрүүлэх замаар өөрчлөхөд чиглэдэг. Психоаналитик баримжаатай эмчилгээ нь эмч, өвчтөн хоёрын нягт хамтын ажиллагаатай холбоотой байдаг. Энэхүү эмчилгээний үед өвчтөнүүд эмчилгээний харилцан үйлчлэлийг судлах замаар өөрсдийнхөө талаар суралцдаг.

2. Зан үйлийн эмчилгээ

Энэ арга нь хэвийн болон хэвийн бус зан үйлийг хөгжүүлэхэд суралцах үүрэг ролийг голлон анхаардаг.

94 *Types and Symptoms of Common Psychiatric Disorders*, Холбоос: <https://www.verywellmind.com/psychiatric-disorder-definition-425317#citation-2>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

95 *ICD-10 Version:2019: (F00-99)*, Холбоос: <https://icd.who.int/browse10/2019/en#/F00-F09>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

3. Танин мэдэхүйн эмчилгээ

Танин мэдэхүйн эмчилгээ нь хүмүүс юу хийж байгаагаас илүүтэйгээр юу бодож байгааг онцолдог.

4. Хүмүүнлэгийн эмчилгээ

Энэ хандлага нь хүмүүсийн оновчтой сонголт хийх чадавхийг онцолж, тэдний чадавхийг дээд зэргээр хөгжүүлдэг.

5. Нэгдсэн эсвэл цогц эмчилгээ

Олон эмч нар өөрсдийгөө ямар нэгэн арга барилтай холбодоггүй. Үүний оронд тэд өөр өөр хандлагын элементүүдийг хольж, үйлчлүүлэгч бүрийн хэрэгцээнд нийцүүлэн эмчилгээгээ тохируулдаг⁹⁶.

Сэтгэл засал болон сэтгэл заслын эмчилгээ гэх нэр томъёоны хувьд анагаахын шинжлэх ухаан болон олон улсын нэвтэрхий толиудад Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад тусгагдсанаас илүү өргөн хүрээнд тодорхойлогдсон байна. Тиймээс тухайн нэр томъёог энэхүү утгаар нь ойлгож, шинэчлэх шаардлагатай.

4.7. “Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн” гэх нэр томъёоны тухайд.

Тус нэр томъёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 20.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.

2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан “Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/” хуулийн 3.1.9-т хүнсний нэмэлт бүтээгдэхүүн гэх нэр томъёог “дангаараа бүтээгдэхүүн, эсхүл хүнсний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж чаддаггүй, тэжээллэг чанаргүй, амт, үнэр, өнгө оруулах, биежүүлэх, сийрэгжүүлэх, хадгалах хугацааг уртасгах болон технологи ажиллагааг хурдасгах зорилгоор хүнсний үйлдвэрлэлийн явцад зориудаар нэмдэг бодис, хольцыг хэлнэ.” гэж тодорхойлсон. Харин хүнс гэдгийг тус хуулийн 3.1.1-т “хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагааг хангах, эрүүл мэндийг дэмжин хамгаалахад шаардагдах хүнсний түүхий эд, хагас болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн, ундны усыг хэлнэ.” гэж тодорхойлсон.

“Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/” хуулийн 16.3-т зааснаар хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэхээр хуульчлагдсан. Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам үүний дагуу нийт 185 төрлийн хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэлжүүлсэн байна. Тухайлбал, Aspartame E951, Allura Red E129, Acesulfame Potassium E950, Brilliant Blue E133, Citric Acid E330, Malic Acid E296, Sodium Dihydrogen Citrate E331, Sunset Yellow E110, Tartrazin E102 XH, Potassium Sorbate E202, Calcium Disodium Edetate E385, Sodium Benzoate E211, Sodium Hexametaphosphate E452 (i), Guar Gum INS E412, Agar Agar INS E406, Propylene glycol INS E1520, Vegetable carbon E153, Green S E142, Sucralose E955, Polydimethylsiloxane E900, Dextrins, roasted starch INS1400, Phosphates E338, Ascorbic acid E300, Acetylated distarch adipate E1422, Carbon dioxide E290, Тосны хүчил E-471, Содиум E-466, Каррагинан E-407, Аскорбилын эфирүүд, Токоферол

96 American Psychological Association: *Different approaches to psychotherapy*, Холбоос: <https://www.apa.org/topics/psychotherapy/approaches>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

Е-307, Цахиурын 2-ч исэл Е-551, Улаан будаг Е-124, Ногоон будаг Е-143, Шар будаг Е-172 гэх мэт 185 төрлийн хүнсний нэмэлт бүтээгдэхүүн тус жагсаалтад бүртгэгдсэн байна⁹⁷. Мөн үүнээс гадна Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр А/515 тушаалаар батлагдсан “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ын 3.1-т зааснаар “Бүртгүүлэх хүнсний нэмэлт нь Хүнсний хууль эрх зүйн хорооны “Codex stan 192-1995, “Хүнсний нэмэлтийн ерөнхий стандарт”-ын “Хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэхийг зөвшөөрсөн хүнсний нэмэлтийн жагсаалт” болон Европын холбооны хүнсний нэмэлтийн жагсаалтад тус тус багтсан тохиолдолд дараах бичиг баримтыг үндэслэн бүртгэж, дугаар олгоно.” гэж хэрэглэгдэх стандартыг зохицуулсан байна. Одоогийн байдлаар MNS CAC 192 : 2015 гэх стандарт хүнсний нэмэлт бүтээгдэхүүний хувьд дотоодын эрх зүйн зохицуулалтын хувьд үйлчилж байна⁹⁸.

Европын хүнсний аюулгүй байдлын байгууллага (EFSA) нь хүнсний нэмэлт бүтээгдэхүүний талаар тодорхойлолт болон стандартыг боловсруулсан байна. Европын хүнсний аюулгүй байдлын байгууллага (EFSA) нь Европын хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагууд (Комисс, Зөвлөл, Парламент) болон ЕХ-ны гишүүн орнуудаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг Европын Холбооноос санхүүжүүлдэг Европын агентлаг юм. Энэ нь 1990-ээд оны сүүлээр болсон хүнсний хямралын дараа 2002 онд байгуулагдсан бөгөөд хүнсний сүлжээтэй холбоотой эрсдэлүүдийн талаар шинжлэх ухааны зөвлөгөө өгөх, харилцааны эх сурвалж болох юм. Тус агентлаг нь ЕХ-ноос “Хүнсний ерөнхий хууль - 178/2002” журмын дагуу хууль ёсоор байгуулагдсан.

Тус байгууллагын тодорхойлсноор хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг “шим тэжээлийн төвлөрсөн эх үүсвэр (жишээлбэл, эрдэс ба витамин) эсвэл “тун” хэлбэрээр (жишээ нь, эм, шахмал, капсул, хэмжсэн тунгаар шингэн) худалдаалагдаж буй хоол тэжээлийн болон физиологийн нөлөө бүхий бусад бодис юм. Витамин, эрдэс бодис, амин хүчил, чухал тосны хүчил, эслэг болон төрөл бүрийн ургамал, ургамлын ханд зэрэг олон төрлийн шим тэжээл болон бусад орц найрлага нь хүнсний нэмэлт тэжээлд агуулагдаж болно.” гэж тодорхойлсон. Хүнсний нэмэлтүүд нь хоол тэжээлийн дутагдлыг арилгах, тодорхой шим тэжээлийн бодисын зохистой хэрэглээг хангах эсвэл физиологийн тодорхой үйл ажиллагааг дэмжих зорилготой юм. Эдгээр нь эмийн бүтээгдэхүүн биш тул фармакологийн, дархлаа судлалын болон бодисын солилцооны үйл ажиллагаа явуулах боломжгүй юм. Тиймээс тэдний хэрэглээ нь хүний өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, физиологийн үйл ажиллагааг өөрчлөхөд зориулагдаагүй болно⁹⁹.

Европын холбооны зохицуулалтад дараах Е дугаартай өнгө, хадгалалтын бодис, антиоксидант, чихэрлэг бодис, эмульгатор, тогтворжуулагч, өтгөрүүлэгч болон бусад төрлийн нэмэлтүүдийг зөвшөөрсөн байна.

97 Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, *Хүнсний нэмэлтийн бүртгэл, Холбоос*: <https://mofa.gov.mn/exp/blog/10/2149>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

98 Стандарт хэмжил зүйн газар, *Хүнсний нэмэлт, Холбоос*: <https://www.estandart.gov.mn/standard/v/6906>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

99 *Food supplements*, Холбоос: <https://www.efsa.europa.eu/en/topics/topic/food-supplements#:~:text=Food%20supplements%20are%20concentrated%20sources.%2C%20liquids%20in%20measured%20doses>), Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

1. Өнгө оруулагч

Үүнд E100 Куркумин, E101 (i) Рибофлавин, (ii) Рибофлавин-5-фосфат, E102 Тартразин, E104 Хинолин шар, E110 Нар жаргах шар FCF; Улбар шар C, E120 Cochineal; кармины хүчил; Карминууд, E122 Азорубин; Кармуазин, E123 Амарант, E124 Ponceau 4R; Cochineal Red A, E127 Эритрозин, E129 Allura Red AC, E131 Патент Цэнхэр V гэх мэт бодисууд хамаарч байна.

2. Хадгалалтын бодис

Үүнд E200 Сорбины хүчил, E202 Калийн сорбат, E210 Бензойн хүчил, E211 Натрийн бензоат, E212 Калийн бензоат, E213 Кальцийн бензоат, E214 Этил р-гидроксibenзоат, E215 Натрийн этил р-гидроксibenзоат, E218 Метил р-гидроксibenзоат, E219 Натрийн метил р-гидроксibenзоат, E220 Хүхрийн давхар исэл, E221 Натрийн сульфит, E222 Натрийн устөрөгчийн сульфит, E223 Натрийн метабисульфит, E224 Калийн метабисульфит гэх мэт бодисууд хамаарч байна.

3. Антиоксидантууд

Үүнд E300 аскорбины хүчил, E301 Натрийн аскорбат, E302 Кальцийн аскорбат, E304 Аскорбины хүчлийн тосны хүчлийн эфир, E306 Токоферол, E307 Альфа-токоферол, E308 Гамма-токоферол, E309 Дельта-токоферол, E310 Пропил галлат, E315 Эриторбины хүчил, E316 Натрийн эриторбат, E319 Гуравдагч бутил гидрохинон (TBHQ), E320 Бутилжуулсан гидроксианизол (BHA), E321 Бутилжуулсан гидрокситолуол (BHT), E392 Розмарины ханд, E586 4-Гексилрезорцинол гэх бодисууд хамаарч байна.

4. Амтлагчууд

Үүнд E420 (i) Сорбитол, (ii) Сорбитолын сироп, E421 Маннитол, E950 Acesulfame K, E951 аспартам, E952 Цикламын хүчил ба түүний Na, Ca давсууд, E953 лсоалт, E954 Сахарин ба түүний Na, K, Ca давсууд, E955 Сукралоз, E957 Тауматин, E959 Неозэсперидин DC, E960 Стевиол гликозид, E961 Neotame, E962 Аспартам-ацесульфамын давс, E964 полигликитол сироп, E965 (i) Мальтитол, (ii) Мальтитол сироп, E966 Лактитол, E967 Ксилитол, E968 Эритритол, E969 Advantame гэх бодисууд хамаарч байна.

5. Эмульгатор, тогтворжуулагч, өтгөрүүлэгч, гель үүсгэгч бодис

Үүнд E322 лецитин, E400 Алгины хүчил, E401 Натрийн алгинат, E402 Калийн алгинат, E403 Аммонийн алгинат, E404 Кальцийн алгинат, E405 Пропан-1,2-диол алгинат, E406 Агар, E407 Карагенан, E407a Боловсруулсан eucheuma далайн замаг, E410 Царцааны бохь; кароб бохь, E412 Гуар бохь, E413 Tragacanth, E414 хуайс бохь; араб бохь, E415 Ксантан бохь, E416 Карая бохь, E417 Тара бохь, E418 Геллан бохь, E425 Конжак гэх мэт бодисууд хамаарч байна.

6. Бусад

Үүнд E260 Цууны хүчил, E261 Калийн ацетат, E262 Натрийн ацетат, E263 Кальцийн ацетат, E270 Сүүн хүчил, E290 Нүүрстөрөгчийн давхар исэл, E296 Алимны хүчил, E297 Фумарын хүчил, E325 Натрийн лактат, E326 Калийн лактат, E327 Кальцийн лактат, E330 Нимбэгийн хүчил, E331 Натрийн цитратууд, E332

Калийн цитратууд, E333 Кальцийн цитратууд, E334 Тартарийн хүчил (L-(+)), E335 Натрийн тартратууд, E336 Калийн тартратууд гэх мэт бодисууд хамаарч байна¹⁰⁰.

Тухайн тодорхойлолтуудаас нэгтгэн дүгнэвэл хүнсний нэмэлт буюу хүнсний нэмэлт бүтээгдэхүүн гэх нэр томьёо нь дотоодын эрх зүйн зохицуулалт болон олон улсын эрх зүйн зохицуулалтад шинжлэх ухааны үндэстэйгээр тусгагдан зохицуулагдаж буй болох нь харагдаж байна. Дотоодын эрх зүйн зохицуулалтын хувьд явцуу хүрээнд зохицуулагдсан байгаа хэдий ч тухайн нэр томьёоны агуулгыг ерөнхийд нь илэрхийлсэн байна.

4.8. “Донтох зуршлын эсрэг эмчилгээ” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт тусгагдсан байна. Тус зохицуулалтад “Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, согтуурах, мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.” гэж тодорхойлогдсон байна.

Согтуурах донтой этгээд гэж согтууруулах ундааны зүйлийг байнга хэрэглэж хэвшсэн түүнээсээ гадны нөлөөгүйгээр ангижрах чадваргүй донтсон хүнийг хэлнэ.

Мансуурах донтой этгээд гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, мансууруулах үйлчилгээний зүйлийг байнга хэрэглэж сэтгэл хөөрлийн байдалд орж заншсан, түүндээ хэт автагдсан хүнийг ойлгоно. Согтуурах болон мансуурах донтой этгээдийг Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд заасан журмаар эмчилж болно.¹⁰¹

Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-д зааснаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт тус клиникийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ба хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, хяналт тавих үүрэг бүхий хяналтын прокуророос бусад хүмүүсийг орохыг хориглоно. Хэрэв ажлын шаардлагаар зайлшгүй орох хүмүүсийг эмнэлгийн удирдлагын зөвшөөрлөөр зөвхөн ажлын цагаар нэвтрүүлнэ.
2. Эмнэлгийн захиргаанаас баталсан цагийн хуваарийн дагуу албадан эмчлүүлэгчдийг дулааны улиралд өдөрт 2 удаа, хүйтний улиралд өдөрт 1 удаа 2 цагаас илүүгүй хугацаагаар хамгаалалтын ажилтан, асрагч нарын хяналтанд нар, салхинд гаргана.
3. Албадан эмчлүүлж буй этгээдийн харьяалах нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч тухайн этгээдийн сэтгэц засралын байдлын талаар сар тутам эмчилж буй байгууллагаас тодорхойлолт авч, хяналтын хувийн хэрэгт хавсаргаж ажиллана.

100 *Food standard agency: Approved additives and E numbers*, Холбоос: <https://www.food.gov.uk/business-guidance/approved-additives-and-e-numbers>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

101 Г.Гантөмөр, С.Гантулга, Б.Энхболд, Л.Бат-Очир, Ж.Төгс-Очир нар, *Эрүүгийн эрх зүйн Ерөнхий анги сурах бичиг*, (УБ, 2020), 430 дахь тал.

4. Эмчлүүлэгч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй үйлдэл хийсэн болон хийхээр завдсан, эмчилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд үзүүлж буй эсэргүүцлийн шинж, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан тусгай хэрэгсэл /резинэн бороохой, гав, нулимс асгаруулагч хий, хүлэг, ороох цамц, зөөлөн даруулга/-ийг холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэглэж, энэ тухай тэмдэглэл үйлдэж, харуул хамгаалалтын хэсгийн даргад танилцуулна. Харуул хамгаалалтын хэсгийн дарга нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд энэ тухай мэдэгдэнэ.

Эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг шүүх тогтооно гэж хуульчилсан боловч Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тодорхойлоогүй байна.

Шүүхийн практикаас үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тусгай тасаг буюу “Шүүхийн сэтгэц, эмгэг судлалын клиник”, энгийн буюу ердийн тасаг болох “Сэтгэцийн эмгэг судлалын 2,3,4,5,6 дугаар клиник”-ийн тасагт эмчлүүлэхээр шийдвэрлэж байна. Цаашид уг арга хэмжээний төрөл, дэглэмийг Эрүүгийн хуульд хуульчлах шаардлагатай.

Эмчилгээний хугацааг шүүх шинжээчийн дүгнэлтийг харгалзан тогтооно гэж заасан. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж буй шүүхийн практикаас үзэхэд нэг сараас 8 жил хүртэл хугацаагаар эмчлүүлэхээр шийдвэрлэж байна.¹⁰²

2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хурлаас “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай/Шинэчилсэн найруулга/” хуулийг баталсан.

Тус хуулиар согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх ерөнхий журмыг дараах байдлаар хуульчилсан байна.

Албадан эмчилгээг тухайн эмгэгийн үед баримталдаг оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийн дагуу явуулахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандах;
- Эмчлүүлэгчийн нууцыг хадгалах;
- Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, бэлдмэлийг хэрэглэх;
- Албадан эмчилгээг байнгын харуул хамгаалалт бүхий эмнэлэгт явуулна;
- Албадан эмчлэх эмнэлэг энэ хуулийн 15.1-д заасны дагуу шаардлагатай шинжилгээ, эмчилгээг хийж, албадан эмчилгээний явцыг өвчний түүхэнд үнэн зөв, тодорхой бичнэ;
- Эмчлүүлэгч эмчилгээ хийлгэхээс татгалзвал түүнд харуул хамгаалалтын ажилтны хяналтан доор эмчийн заавраар албадан эмчилгээг хийж, энэ тухай өвчний түүхэнд тэмдэглэнэ;

102 Г.Гантөмөр, С.Гантулга, Б.Энхболд, Л.Бат-Очир, Ж.Төгс-Очир нар, *Эрүүгийн эрх зүйн Ерөнхий анги сурах бичиг*, (УБ, 2020), 427 дахь тал.

- Эмчлүүлэгч өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй байдалд орсон тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасан журмын дагуу тусгаарлах болон номхотгох аргыг хэрэглэж болно;
- Албадан эмчлүүлж байгаа хүнд сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлнэ;
- Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээний хүрээнд явуулах нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээ нь эмчлүүлэгчийн биеийн байдал, мэргэжил, хөдөлмөрийн чадвар, нас биеийн онцлогт тохирсон байна.

2014 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй Донтолтын төв (Addictive center) нь мансууруулах бодис хэрэглэх эмгэг, зан үйлийн болон сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгтэй тэмцэж буй хүмүүст зориулсан мэдээллийн вэб хөтөч бөгөөд тус байгууллага нь дэлхийн хэмжээний сэргээн засах байгууллагын харьяанд байдаг. Тус байгууллагын үзэж буйгаар донтох зуршлын эсрэг дараах эмчилгээнүүд байхаар тодорхойлогдсон байна.

Тус эмчилгээний хөтөлбөрүүд нь хүн бүрт өөр өөр байдаг бөгөөд өвөрмөц хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэгдэн өөрчлөгдөж болно. Хамгийн үр дүнтэй эмчилгээний хөтөлбөрүүд нь эдгэрч буй хүмүүсийг алхам тутамд идэвхтэй оролцуулах боломжийг олгодог. Энэ нь:

1. Эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх;
2. Амбулаторийн нөхөн сэргээх эмчилгээ;
3. Хоргүйжүүлэх;
4. Гэрт нь байлгаж эрүүлжүүлэх;
5. Донтолтыг эмчлэх эмүүдийг хэрэглэх;
6. Хөндлөнгөөс оролцож эмчлэх;
7. Итгэл дээр суурилсан эмчилгээ.

Мөн тухайн эмчилгээнүүдээс гадна дараах сэтгэл заслын эмчилгээнүүд донтох зуршлын эсрэг эмчилгээнд хамаарч байна. Үүнд:

1. Биологийн хариу урвалын эмчилгээ;
2. Танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ;
3. Диалектик зан үйлийн эмчилгээ;
4. Туршлагад суурилсан эмчилгээ;
5. Нэгдмэл эмчилгээ;
6. Урам зориг өгөх эмчилгээ;
7. Психодинамик эмчилгээ.¹⁰³

Дээрхээс дүгнэвэл “донтох зуршлын эсрэг эмчилгээ” гэх нэр томьёог дотоодын эрх зүйн эх сурвалжид процессын асуудлыг илүү нарийн зохицуулсан болох нь харагдаж байна. Гэвч тухайн нэр томьёог нарийн тодорхойлсон тодорхойлолт тухайн журмуудад тусгагдаагүй байна. Мөн процессын тодорхойгүй байдал болон давхардал бий болж байна.

103 *Types Of Treatment: Addiction center*, Холбоос: <https://www.addictioncenter.com/treatment/>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

V. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ХҮН АМ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА

5.1. “Орон байр” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 13.6 дугаар зүйлийн 1,2 дэх хэсэг, 13.8 дугаар зүйлийн 1,3 дахь хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 20.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 29.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

Канад улсын статистикийн хүрээлэнгийн “Census” толь бичигт хүн эсвэл бүлэг хүмүүс оршин суух эсвэл оршин суух боломжтой хүний оршин суух зориулалттай эсвэл өөрчилсөн тусдаа орон сууцны багц; түүнчлэн хувийн орон сууц нь дулаан, эрчим хүчний эх үүсвэртэй байх ёстой бөгөөд байгаль орчны сөрөг нөлөөллөөс хамгаалах битүү орон зай байх ёстой бөгөөд энэ нь иж бүрэн, битүү хана, дээвэр, салхи, бороо, цас, салхинаас хамгаалсан хаалга, цонхоор хүрээлэгдсэн байдаг гэж тодорхойлсон.¹⁰⁴

Америкийн нэгдсэн улсын Дээд шүүхийн шүүгч Харлан “Katz v. United States” хэргийг шийдвэрлэхдээ орон байр гэх нэр томьёоны тайлбарыг хийсэн юм. Katz v. United States хэргийн тухайд “Холбооны мөрдөх товчооны мөрдөгчид Катзыг утасны бүхээгт утсаар ярьж байхад гаднаас нь чагнах төхөөрөмж тавьсан. Дүүргийн шүүх утасны яриаг Катзын эсрэг нотлох баримтаар ашигласан. Улмаар түүнийг АНУ-ын мужуудаар утсаар бооцооны мэдээлэл дамжуулсан хэргээр ял сонгосон. Үүний дагуу тэрээр цахим төхөөрөмж ашиглан олж авсан нотлох баримтыг Америкийн нэгдсэн улсын Үндсэн хуулийн дөрөв дэх нэмэлт, өөрчлөлтийн эрхийг зөрчсөн гэж үзэн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахаар болжээ.”¹⁰⁵ гэх товч агуулгатай байна. Америкийн нэгдсэн улсын Үндсэн хуулийн дөрөв дэх нэмэлт, өөрчлөлтийн хувьд “Ард түмний бие, орон байр, бичиг баримт, эд зүйлд үндэслэлгүй нэгжлэг, хураан авахаас хамгаалсан байх эрхийг зөрчиж болохгүй байх эрх”-ийг баталгаажуулж өгсөн байдаг. Америкийн нэгдсэн улсын Дээд шүүхийн шүүгч Харлан тус хэргийг шийдэхдээ хүний хувийн халдашгүй байдлыг дараах байдлаар тайлбарласан юм. Ингэхдээ утасны бүхээгт тухайн хүн өөрийн хувийн орон зайг мэдэрч, субъектив төсөөлөлтэй байсан, нийгмийн зүгээс тухай үйлдлийг хүлээн зөвшөөрсөн учир орон байртай адилтган чагнах төхөөрөмж тавьсныг тухайн хүний эрхийг зөрчсөн гэж үзэж ийнхүү зөвшөөрөлгүй тагнасан нь буруу юм гэж үзсэн. Ерөнхийдөө Америкийн нэгдсэн улсын Дээд шүүх Америкийн нэгдсэн улсын Үндсэн хуулийн дөрөв дэх нэмэлт, өөрчлөлт нь тухайн хүний байгаа орон байрыг бус тухайн хүнийг хамгаалдаг гэж үзсэн. Гэхдээ хүмүүст ямар хамгаалалт өгөх талаар асуудал тулгарна. Энэ нь орон байр гэдгээс эх үндэстэй байх ёстой. Өмнөх шийдвэрүүдээс үзвэл орон байрны халдашгүй байдал нь хоёр шаардлага биелснээр бий болохоор дүгнэгдэж байна. Нэгдүгээрт хүн хувийн халдашгүй байдлаа мэдрэх субъектив төсөөлөл бий болох, хоёрдугаарт нийгэм үүнийг үндэслэлтэй гэж ойлгох гэсэн хоёр шалгуур үүнд хамаарч байна. Тийм учраас тухайн хүний гэр нь хувийн халдашгүй байдлыг хадгалах орчин болдог хэдий ч үзэсгэлэн гэх мэт зүйлийг гаргахад энэхүү шинжээ алддаг байна. Өөрөөр хэлбэл нээлттэй хэн нэгэнтэй ярилцах үед тухайн хүн үүнийг хувийн нууц гэж бодохгүй бөгөөд хувийн халдашгүй байдлын төсөөлөл

104 Dwelling, private - 2011 Census Dictionary

105 U.S. Reports: Katz v. United States, 389 U.S. 347 (1967), Холбооц: <https://privacylibrary.ccnlud.org/case/katz-vs-united-states>, Сүүлд үзсэн огноо:2022.04.15

байхгүй байх ба энэ үед хувийн халдашгүй байдал яригдахгүй юм.¹⁰⁶

Хууль зүйн хувьд Эрүүгийн хуулийн 13.6 дугаар зүйлийн аутентик тайлбарт “Энэ хуульд заасан “орон байр” гэж хүн байнга, түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно.” гэж тодорхойлсон байна.

Дээрх байдлаас дүгнэвэл орон байр гэх нэр томьёо нь орон байрны халдашгүй байдлаас эхтэй ойлголт учир тухайн агуулгаас гажиж болохгүй байна. Тиймээс дээрх онолын тодорхойлолт болон нэрлэн заасан 2 шаардлагад нийцэх ёстой. Монгол Улсын Эрүүгийн хуульд орон байр гэх нэр томьёог тайлбарлахдаа тоочиж орон байрын төрлүүдийг заасан байгаа нь үүний агуулгыг гаргаж, зохистой зохицуулахгүй байна.

Эцэст нь дүгнээд үзвэл орон байр гэх нэр томьёог Монгол Улсын Эрүүгийн хуульд аутентик тайлбараар тоочсон байдлаар тайлбарлаж зохицуулсан. Тайлбарласан эрдэм, шинжилгээний бүтээлүүд буюу онол болон гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтуудад тоочсон, ерөнхий байдлаар зохицуулсан янз бүр байна. Орон байр гэх нэр томьёо нь нийгмийн шинжлэх ухааны талаас онолын хувьд тайлбарлагдах ойлголт учир тухайн нэр томьёог тоочсон байдлаар бус ерөнхий байдлаар зохицуулж онолын дагуу ойлгох нь зүйтэй байна.

5.2. “Асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 10.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 16.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

Эрх зүйн толь бичигт асран хамгаалагч (англ. caretaker; custodian; guardian; trustee; tutor; ор. опекун) гэдгийг эд хөрөнгийн зохих бололцоотой төрөл, садан буюу төрөл, садан бус хүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг нь үндэслэн сум, дүүргийн Засаг даргаас бага насны хүүхдийг асран хамгаалуулахаар тогтоосон иргэн¹⁰⁷ гэж тодорхойлсон байна.

Харин харгалзан дэмжигч гэдгийг тухайн толь бичигт “Иргэний амин хувийн ба эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн хэлбэрийн нэг. Иргэний ба гэр бүлийн хуулиар зохицуулагдана. Харгалзан дэмжигчийг 14-өөс 18 хүртэл насны насанд хүрээгүй иргэнд тогтооно. Насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хийнэ. Тэрчлэн Монгол Улсын Иргэний хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийн иргэний эрх зүйн чадамжийг сонирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх хуулиар тогтоосон журмаар хязгаарлаж, харгалзан дэмжигч томилж болно. Иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан этгээд хязгаарлагдаагүй чадамжийнхаа хүрээнд, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийнэ¹⁰⁸.” гэж тайлбарласан байна.

106 U.S. Reports: Katz v. United States, 389 U.S. 347 (1967), p.361, Холбоос: <https://tile.loc.gov/storage-services/service/ll/usrep/usrep389/usrep389347/usrep389347.pdf>, Сүүлд үзсэн огноо:2022.04.15.

107 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (УБ, 2007), 47 дахь тал.

108 С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, (УБ, 2007), 505 дахь тал.

Асран хамгаалах, харгалзан дэмжих гэдэг нь насны болон эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлын хувьд эрхийн тусгай хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа иргэнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоож тэдний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг ойлгоно. Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны зорилго нь асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байх хүний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх ашиг сонирхлыг хамгаалах, тэднийг зөв боловсон өсгөж хүмүүжүүлэх, эрүүл энх, ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд оршдог. Асран хамгаалах ба харгалзан дэмжих нь зорилгоороо адил боловч асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байх хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүргээр хоорондоо ялгагдана¹⁰⁹.

Монгол Улсын 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Гэр бүлийн тухай хуульд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн талаар эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан байна.

Тус хуулийн 63 дугаар зүйлд дараах хүмүүсийг асран хамгаалалтад байхаар хуульчилсан байна. Үүнд:

- Бага насны /14 нас хүрээгүй/ бүтэн өнчин хүүхэд;
 - Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд;
 - Эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд;
 - Сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн;
 - Бүтэн өнчин ах, эгч, дүү нарт нэг асран хамгаалагч тогтоож болно.
- Мөн тус хуулийн 64 дүгээр зүйлд харгалзан дэмжвэл зохих хүн хэмээн дараах хүмүүсийг хуульчилсан байна. Үүнд:
- Насанд хүрээгүй /14-өөс 18 хүртэлх насны/ бүтэн өнчин хүүхэд;
 - Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний насанд хүрээгүй хүүхэд;
 - Эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний насанд хүрээгүй хүүхэд;
 - Согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэсний улмаас иргэний эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн;
 - Эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон хүн.
- Үүнээс гадна тухайн хуулийн 67,68 дугаар зүйлд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох талаар хуульчилсан байна.
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг дор дурдсан журмаар тогтооно:
- Эд хөрөнгийн зохих бололцоотой төрөл, садан буюу төрөл, садан бус хүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг нь үндэслэн сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоох;

109 А.Дугармаа, *Гэр бүлийн эрх зүй: Онол, бодлого, сорил, нэр томьёо*, (УБ, 2016), 141-142 дахь тал.

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол хүүхдийг нас, эрүүл мэндийн байдлыг нь харгалзан хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх;
- Харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол өндөр настан, тахир дутуу хүнийг асрамжийн газарт шилжүүлэх;
- Сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүнийг сэтгэл мэдрэлийн эмнэлэгт болон холбогдох байгууллагад шилжүүлэх.

Тухайн хүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай байгаа тухай мэдээллийг аливаа байгууллага, иргэн холбогдох сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг асран хамгаалж, харгалзан дэмжихэд тус хуулийг дагаж мөрдөнө. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэнд тухайн улсын хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд тооцно. Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааг үнэ төлбөргүй гүйцэтгэнэ.

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр дараах хүнийг тогтоож болохгүй. Үүнд:

- Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан;
- Өөрөө асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа;
- Мансууруулах бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг;
- Хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн;
- Үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн.

Харгалзан дэмжигч болон асран хамгаалагч гэх нэр томьёо нь эртний Ромын эрх зүйгээс үүсэлтэй байна. Ромын эрх зүйгээр асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг ялгаж байв. Асран хамгаалагчийг насанд хүрээгүй хүүхэд, эмэгтэйчүүдэд (нас харгалзахгүй) томилдог байсан бол харгалзан дэмжигчийг 25 нас хүрээгүй насанд хүрсэн субъект харгалзан дэмжигч томилуулахыг хүсвэл түүний эрх зүйн чадамж хязгаарлагдаж, энэ үндсэн дээр өөртөө хохирол учруулахаар буюу тухайлбал эд хөрөнгөнийх нь хэмжээ багасахаар хэлцэл байгуулах болвол заавал харгалзан дэмжигчийн зөвшөөрөл (consensus) авах шаардлагатай байв. Эрэгтэй 14-25, эмэгтэй 12-25 насны субъект нь харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр гэр бүл болох, гэрээслэл үйлдэх эрхтэй. Харин сэтгэл мэдрэлийн өвчтэй, оюун ухааны хомсдолтой субъектыг эрх зүйн чадамжгүй гэж үзэж, харгалзан дэмжигчийн хяналтад байлгадаг. Өөрийн эд хөрөнгийг зөв захиран зарцуулж чаддаггүй, үгүйрэн хоосрох нөхцлийг бүрдүүлсэн үрэлгэн этгээдийн эрх зүйн чадамж нь хязгаарлагдаж, харгалзан дэмжигчийг томилдог.¹¹⁰

Гадаадын эрх зүйн толь бичигт асран хамгаалагч гэдгийг бусдын хүн эсвэл эд хөрөнгийг халамжлах хууль ёсны эрх мэдэл, үүрэг гүйцэтгэдэг хүн бөгөөд ялангуяа насанд хүрээгүй, чадваргүй, хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ нь хамаарна. Асран хамгаалагч бүх зорилгоор эсвэл тодорхой зориулалтаар томилогдсон байж болно¹¹¹. Харин харгалзан дэмжигч гэдгийг харгалзан дэмжих эсвэл асрамжлах хүн эсвэл байгууллага гэж тодорхойлсон. Энэ нь хүүхэдтэй холбоотой, асран хамгаалагч нь

110 Х.Сэлэнгэ, *Ромын эрх зүй хоёрдахь хэвлэл*, (УБ, 2002), 28-29 дэх тал.

111 Bryan A. Garner, *Black's law dictionary: Eight edition*, (Thomson West, 2004), p.2074.

хууль ёсны эсвэл бие махбодын хамгаалалттай байдаг.¹¹²

Дээрхээс дүгнэвэл дотоодын эрх зүйн зохицуулалт болон олон улсад тодорхойлсон тодорхойлолт нь хооронд агуулгын хувьд ижил байгаа бөгөөд асран хамгаалагч болон харгалзан дэмжигчийг дээрх утгаар нь ялган зааглаж Эрүүгийн хуульд хэрэглэх нь зүйтэй.

5.3. “Харьяалалгүй хүн” гэх нэр томъёоны тухайд.

Тус нэр томъёо нь Эрүүгийн хуулийн 1.6 дугаар зүйлийн 1, 4 , 5 дахь хэсэг, 1.7 дугаар зүйлийн 2,3 дахь хэсэг, 19.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 19.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус тус тусгагдсан байна.

2010 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай” хуулийн 5.1.7-т зааснаар харьяалалгүй хүн гэдгийг аль ч улсын харьяат бус хүнийг хэлэхээр тодорхойлсон.

Эрх зүйн толь бичигт харьяалалгүй хүн буюу этгээдийг “(англ. person out of citizenship; ор. лицо безгражданства) тухайн улсын иргэн биш, түүнийг ямар нэгэн гадаад улсын иргэнд хамаарахыг тогтоож болохуйц холбогдох нотлох баримт байхгүй этгээдийн эрх зүйн байдал. Өөрийн улсын иргэний харьяаллаа алдсан ба шинээр олж авч чадаагүй этгээдийн тохиолдолд харьяалалгүй болох явдал үүсэж болно. Энэ учраас харьяалалгүй этгээд нь үнэмлэхүй (төрсөн үеэс) ба харьцангуй (харьяатаа алдсан) байж болно. Монгол Улсад харьяалалгүй этгээдэд (гадаадын иргэний адил) үндэсний дэглэмийг хэрэглэнэ. Харьяалалгүй этгээд ба гадаадын иргэн улс төрийн зарим эрх (жишээ нь сонгуулийн эрх) эдлэхгүй. Улсууд олон улсын тусгай хэлэлцээр байгуулах замаар харьяалалгүй этгээдийг аль болохоор хязгаарлахыг эрмэлзэж байна.” гэж тодорхойлсон байна.

Монгол хэлний тайлбар тольд харьяалалгүй хүн гэдгийг ямар нэгэн улс болон түүний тодорхой системийн харьяанд бүртгэлгүй хүн¹¹³ гэж тайлбарласан байна.

Олон улсын нэвтэрхий толь бичигт харьяалалгүй хүн гэдгийг ямар нэг улсад харьяалагддаггүй хүнийг¹¹⁴ хэлэхээр тодорхойлсон байна.

Олон улсын эрх зүйн толь бичигт “Аль ч улсын харьяат гэж тооцогддоггүй хувь хүн. Харьяалалгүй хүмүүсийн тухай конвенцид (1954) эдгээр хүмүүст тодорхой хамгаалалтууд олгож, оршин суугаа улсынхаа хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг үүрэг болгосон¹¹⁵.” гэж харьяалалгүй хүний тухай тодорхойлолтыг бичсэн байна.

Олон улсын эрх зүйн зохицуулалтын хувьд харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай олон улсын гэрээ гаргах замаар түүнийг тодорхойлж эрх зүйн хамгаалалтад авсан байна. 1954 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Нэгдсэн үндэстний байгууллагын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 526 А (XVII) тогтоолоор боловсруулагдсан, 1954 оны 9-р сарын 28-нд хуралдсан Бүрэн эрхт төлөөлөгчдийн бага хурлаар баталсан 1960 оны 6-р сарын 6 хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн

112 Bryan A. Garner, *Black's law dictionary: Eight edition*, (Thomson West, 2004), p.1161.

113 *Монгол хэлний их тайлбар толь*, Холбоос: <https://mongoltoli.mn/dictionary/detail/107251>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

114 *Britannica: nationality*, Холбоос: <https://www.britannica.com/topic/nationality-international-law>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

115 Bryan A. Garner, *Black's law dictionary: Eight edition*, (Thomson West, 2004), p.4409.

“Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц” нь тухайн олон улсын гэрээнд хамаарч байх ба “харьяалалгүй хүн” хэмээх нэр томьёог тайлбарласан байна. Монгол Улс нь энэхүү олон улсын гэрээнд одоогийн байдлаар нэгдэж ороогүй байна.

“Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц”-ын 1 дүгээр зүйлд зааснаар харьяалалгүй хүн гэх нэр томьёог хууль тогтоомжийн дагуу аль ч улсын харьяат гэж тооцогддоггүй хүнийг хэлнэ¹¹⁶ гэж тодорхойлсон байна.

Дээрх тодорхойлолтуудаас үзвэл дотоодын эрх зүйн тогтолцоонд харьяалалгүй хүн гэх нэр томьёог тодорхойлсон нь бусад тодорхойлолтуудтай ерөнхийдөө нийцэж байна. “Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц”-д зааснаар хууль тогтоомжийн дагуу аль ч улсын харьяат бус байх шаардлага тавигдаж байна. 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан “Харьяатын тухай хууль”, 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-иар тус харьяалалгүй этгээд байх шаардлагыг дотоодын эрх зүйн зохицуулалтад тусгаагүй байна. Харин Гадаадын иргэн, харьяатын газрын чиг үүрэгт харьяалалгүй хүнийг бүртгэх чиг үүрэг хамаарч байна.¹¹⁷ Тиймээс харьяалалгүй хүн гэх нэр томьёог дээрх тодорхойлолтод тусгагдсан байдлаар ойлгох нь зүйтэй.

116 Convention relating to the Status of Stateless Persons Adopted on 28 September 1954 by a Conference of Plenipotentiaries convened by Economic and Social Council resolution 526 A (XVII) of 26 April 1954.

117 *Гадаадын иргэн, харьяатын газар: Чиг үүрэг*, Холбоос: <https://immigration.gov.mn/mn/chig-uureg/>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

VI. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА

6.1. “Хор хөнөөлт программ хангамж” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

Европын мэдээлэл сүлжээний аюулгүй байдлын агентлагийн гарын авлагад Malware гэх үг нь MALicious softWARE буюу хор хөнөөлт программ хангамж гэсэн үгний товчлол юм гэж тодорхойлжээ . Хор хөнөөлт программ хангамж /malware/ нь таны зөвшөөрөлгүйгээр таны компьютерт нэвтрэн орох зориулалттай бүтээгдсэн дайсагнасан эсвэл халдлагат программ юм.¹¹⁸

Тухайн программ нь хор хөнөөлт программ байхын тулд дараах хоёр шалгуурт нийцсэн байх ёстой:

1. Дайсагнасан эсвэл халдлагат;
2. Таны зөвшөөрөлгүй таны компьютерт орсон байх.

Хор хөнөөлт программ нь дата эсвэл файл устгах, бусад компьютерт халдах, эсвэл таны зөвшөөрөлгүй бусад үйлдлүүдийг хийдэг. Сүүлийн жилүүдэд программчид хамгийн олон давтамжтай хэрэглэгддэг хор хөнөөлт программ хангамжийг мэдээ мэдээлэл хулгайлах, бусад компьютерыг доголдуулах эсвэл залилах гэмт хэрэг үйлдэхэд ашигладаг байна. Жил ирэх тусам хор хөнөөлт программ хангамж нь улам их ихсэж байгаа бөгөөд удаашрах төлөвгүй байна. Программчид байнга шинэ хор хөнөөлт программ хангамж бүтээж байдаг учир хор хөнөөлт программ хангамжийг бүрэн устгах боломжгүй юм.¹¹⁹

Хор хөнөөлт программ хангамж нь дотроо хэд хэдэн төрөлтэй байдаг байна. Олон төрлийн хор хөнөөлт программ хангамж хэд хэдэн ангилалд багтдаг ба системээс системээсрүү шилжихдээ өөрчлөгддөг байна. Хор хөнөөлт программ хангамж нь үргэлж хувьсаж байдаг ба холимог хувилбарууд тогтмол бүтээгдэж байна.

Хор хөнөөлт программ хангамж нь дараах төрөлтэй. Үүнд:

1. Virus;
2. Worm;
3. Trojan horse;
4. Backdoors;
5. Spyware;
6. Keystroke loggers;
7. Botnets;
8. Rootkits.

Хууль зүйн хувьд “хор хөнөөлт программ хангамж” гэх нэр томьёог тайлбарласан тодорхойлолт байдаггүй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “хор хөнөөлт программ хангамж” гэж тодорхойлохын тулд Эрүүгийн

¹¹⁸ European Network and Information Security Agency (ENISA), *Malicious software: train the trainer reference guide*, 2010, p.12.

¹¹⁹ European Network and Information Security Agency (ENISA), *Malicious software: train the trainer reference guide*, 2010, p.12.

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.1 дүгээр зүйлийн 1-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор, эсхүл тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай бол шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргаж шинжилгээ хийлгэнэ.” гэж зааснаар шинжээчийн дүгнэлтээр тодорхойлогдоно.

6.2. “Галт зэвсэг, галт хэрэгсэл” гэх нэр томьёоны тухайд.

Тус нэр томьёо нь 2015 оны Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.2, 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 19.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 20.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 23.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 29.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 29.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тусгагдсан байна.

Галт зэвсэг гэдэг нь “Гол төмөр болон дарьны шаталтын үйлчлэлээр сумыг түлхэх зориулалт бүхий хэрэгсэл. Мөн үүнийг “зэвсэг, буу, гар буу, урт буу, револвер гэх мэт” гэж тодорхойлсон байна. Харин галт хэрэгсэл гэдгийг “Нэг буюу хэд хэдэн хонгио, дэлбэрэх зүйл, сумаас бүрдсэн хайрцаг, багцыг ойлгоно. Гурван үндсэн төрөл нь rimfire, centerfire, shothell юм.¹²⁰”

Галт зэвсгийг нийтлэг байдлаар гар буу(1 удаагийн буудалттай болон хагас автомат); Револвер(дугуй хэлбэрийн цэнэглэх дайзтай); 1 удаагийн буудлагатай урт галт зэвсэг(задардаггүй); задардаг галт зэвсэг (жишээ нь смүтбор, винтов буюу рифл, хосолсон, богино болон урт галт зэвсэг); давтаж бууддаг галт зэвсэг (смүтбор, винтов буюу рифл); хагас автомат урт галт зэвсэг (смүтбор, винтов буюу рифл); бүрэн автомат галт зэвсэг (Довтолгооны винтов буюу рифл, мачин ган, бүтэн автомат гар буу); хошуугаар цэнэглэх галт зэвсэг¹²¹ гэж тодорхойлдог.

Галт зэвсгийг нийтлэг байдлаар гэр(гууль, никель эсвэл гангаар хийгдсэн гэр); тэсрэх бодисыг асаахад ашигладаг цохилтот нунтаг эсвэл нэгдэл агуулсан таг, хоолой, хавтан; дарь/шатагч бодис(Бууны дарь); бууны сум¹²² гэж тодорхойлдог.

2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн “Галт зэвсгийн тухай” хуульд “галт зэвсэг гэдгийг даринь шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг;” гэж тайлбарласан. “Галт хэрэгсэл” гэх нэр томьёог хууль зүйн хувьд тодорхойлсон тодорхойлолт байдаггүй. Тиймээс галт зэвсэг судлалын үүднээс галт хэрэгслийг тодорхойлсон тайлбарыг судалж түүний дагуу тайлбарлаж, ойлгох нь зүйтэй байна.

120 *Tn Courts: Firearm definition*, Холбоос: https://www.tncourts.gov/sites/default/files/docs/firearmshandout_1.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

121 *Table 1: types of firearms, Updated 7 January 2021*, Холбоос: <https://www.gov.uk/government/publications/deactivated-firearms-implementing-regulation-eu-20152403/table-1-types-of-firearms>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

122 *Gunvault:Types of Ammunition*, Холбоос: <https://gunvault.com/types-of-ammunition/>, Сүүлд үзсэн огноо: 2022.04.15.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, шүүхийн шийдвэр

Монгол хэлээр:

1. Эрүүгийн хууль/Шинэчилсэн найруулга/, (2015)
2. Эрүүгийн хууль, (2002)
3. Хууль тогтоомжийн тухай хууль, (2015)
4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, (1994)
5. Газрын тухай хууль, (2002)
6. Малын генетик нөөцийн тухай хууль, (2017)
7. Гойд ашиг шимт мал шалгаруулах журам
8. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, (1961)
9. Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, (1971)
10. Амьтны тухай хууль, (2012)
11. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм
12. Төрийн болон албаны нууцын тухай хууль, (2004)
13. Төрийн нууцын тухай хууль, (1995)
14. Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, (2012)
15. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, (1998)
16. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-н конвенц, (1988)
17. Үр хөндөлтийг зохицуулах журам, (2019)
18. Гэмтлийн зэрэг тогтоох журам, (2014)
19. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенц, (2006)
20. Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам, (2017)
21. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, (2013)
22. Хүнсний тухай хууль, (2012)
23. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэл, түүнд хяналт тавих журам, (2017)
24. Согтууруулах, сансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, (2018)
25. Гэр бүлийн тухай хууль, (1999)
26. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, (2010)

Гадаад хэлээр:

1. THE FAMILY CODE OF THE RUSSIAN FEDERATION <http://www.jafbase.fr/docEstEurope/RussianFamilyCode1995.pdf>
2. Act for Protection of Embryos, https://www.rki.de/SharedDocs/Gesetzestexte/Embryonenschutzgesetz_englisch.pdf?__blob=publicationFile

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. С.Нарангэрэл, “Эрх зүйн эх толь бичиг”, (УБ, 2007)
2. П.Нямдаваа, Н.Наранбаатар, Н.Наранбат, Н.Наранболд, “Анагаах ухааны нэр томьёоны товч тайлбар толь”, (УБ, 2006)
3. С.Гантулга, Б.Энхбаяр нар, Эрүүгийн эрх зүй, тусгай анги” сурах бичиг, (УБ, 2018)
4. Монгол банк, Дэлхийн банк, “Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь”, (2015)
5. Ц.Лхагвасүрэн нар, “Монголын Анагаахын үндэсний нэвтэрхий толь. III боть”, (УБ, 2012)
6. Я.Жамбалдорж, “Анагаах ухааны танин мэдэхүйн толь”, (УБ, 2009)
7. П.Ариунболд, М.Цэрэнбат, Ж.Эрдэнэбулган, “2002 ба 2015 оны Эрүүгийн хууль дахь эмнэлгийн нэр томьёоны харьцуулалт”, Гэмт явдалтай тэмцэх асуудал №1 (2019)
8. Г.Гантөмөр, С.Гантулга, Б.Энхболд, Л.Бат-Очир, Ж.Төгс-Очир, “Эрүүгийн эрх зүйн Ерөнхий анги сурах бичиг”, (УБ, 2020)
9. А.Дугармаа, “Гэр бүлийн эрх зүй:Онол, бодлого, сорил, нэр томьёо”, (УБ, 2016)
10. Х.Сэлэнгэ, “Ромын эрх зүй” хоёрдахь хэвлэл, (УБ, 2002)

Гадаад хэлээр:

1. Heather Bateman, Steve Curtis, Katy McAdam, “Dictionary of Agriculture third edition”, A & C Black Publishers Ltd, 2006
2. Bryan A. Garner, “Black’s law dictionary:Eight edition”, (Thomson West, 2004)
3. John P. Rafferty, ed. (2011): Minerals; p. 1. In the series Geology: Landforms, Minerals, and Rocks. Rosen Publishing Group
4. Bulakh, Hans-Rudolf Wenk,Andrey, “Minerals Their Constitution and Origin”, (Cambridge university press, 2016)
5. “Types of Chemical Weapons” (PDF). www.fas.org. Federation of American Scientists. Archived from the original (PDF) on March 3, 2016. Retrieved June 27, 2016.
6. Dr. Harvey Marcovitch, “Black’s medical dictionary” , (41st ed. 2005)
7. Webster’s new world medical dictionary, (3rd ed. 2008)
8. International classification of impairments, disabilities, and handicaps : a manual of classification relating to the consequences of disease, published in accordance with resolution WHA29.35 of the Twenty-ninth World Health Assembly, May 1976
9. Dr. Harvey Marcovitch, “Black’s medical dictionary” , (41st ed. 2005)
10. European Network and Information Security Agency (ENISA), Malicious software: train the trainer reference guide, 2010

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Тусгай хамгаалалттай газар, <http://mpa.gov.mn/news/885>
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 1994 он, <https://legalinfo.mn/mn/detail/479>
3. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, <https://eic.mn/spalocal/index.php>
4. Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/dictionary/detail/8736>
5. “Х.Нямбаатар:Хурдан удмын адуу хулгайлсан бол хүндрүүлэх нөхцөл болно”, Т.Сайхан, (2020.01.10), <https://www.polit.mn/a/77974>
6. Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ, 2019 он, Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ (gic.mn)
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, <https://mlsp.gov.mn/uploads/files/186924b7c9448142182ac9ad7d5598b4187d7c00.pdf>
8. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_976_976_L32 &type=tables
9. Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам: Хүнсний нэмэлтийн бүртгэл <https://mofa.gov.mn/exp/blog/10/2149>
10. Стандарт хэмжил зүйн газар: Хүнсний нэмэлт, <https://www.standard.gov.mn/standard/v/6906>
11. ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР: Чиг үүрэг, <https://immigration.gov.mn/mn/chig-uureg/>

Гадаад хэлээр:

1. What Does Inorganic Matter Mean?, <https://www.corrosionpedia.com/definition/678/inorganic-matter#:~:text=Inorganic%20matter%20is%20matter%20which,they%20are%20not%3A%20organic%20compounds>
2. Britannica, T. Editors of Encyclopaedia. “geology.” Encyclopedia Britannica, October 25, 2018. <https://www.britannica.com/science/geology>
3. <https://wwf.ru/en/regions/the-caucasus/development-of-system-of-especially-protected-natural-territories/>
4. What is a mineral? By Donald Peck, https://www.mindat.org/a/what_is_a_mineral
5. The New IMA List of Minerals – A Work in Progress – Updated: March 2022, http://cnmnc.main.jp/IMA_Master_List_%282022-03%29.pdf
6. Raw material: Definition, <https://www.britannica.com/dictionary/raw-material>
7. What Are Raw Materials?, <https://www.investopedia.com/terms/r/rawmaterials.asp>
8. Convention on Narcotic Drugs, 1961, <https://undocs.org/en/ST/CND/1/Add.1/Rev.8>
9. Convention on psychotropic substances, 1971, https://www.unodc.org/pdf/convention_1971_en.pdf
10. Narcotic raw materials, https://www.incb.org/pdf/e/estim/trainmat/NAR_1%20English%202005.pdf

11. Chemicals & Raw Materials, <https://www.pharmamanufacturingdirectory.com/category/chemicals-raw-materials>
12. Animal-Derived Raw Material Product Standards, <https://corporate.target.com/sustainability-ESG/environment/animal-welfare/animal-derived-raw-materials>
13. Britannica: biological weapon, <https://www.britannica.com/technology/biological-weapon>
14. Stop Ecocide foundation:Independent Expert Panel for the Legal Definition of Ecocide COMMENTARY AND CORE TEXT, June 2021, <https://static1.squarespace.com/static/5ca2608ab914493c64ef1f6d/t/60d1e6e604fae2201d03407f/1624368879048/SE+Foundation+Commentary+and+core+text+rev+6.pdf>
15. Ecocidelaw:History, <https://ecocidelaw.com/history/>
16. Stop Ecocide foundation:Independent Expert Panel for the Legal Definition of Ecocide COMMENTARY AND CORE TEXT, June 2021, <https://static1.squarespace.com/static/5ca2608ab914493c64ef1f6d/t/60d1e6e604fae2201d03407f/1624368879048/SE+Foundation+Commentary+and+core+text+rev+6.pdf>
17. <https://www.macmillandictionary.com/dictionary/british/state-secret> Сүүлд үзсэн огноо 2021.12.15
18. Cambridge dictionary:Official secret, <https://dictionary.cambridge.org/dictionary/english/official-secret>
19. Pornography:sociology, By John Philip Jenkins, <https://www.britannica.com/topic/pornography>
20. Pornography:sociology, By John Philip Jenkins, <https://www.britannica.com/topic/pornography>
21. National cancer institution, Dictionary of cancer terms, <https://www.cancer.gov/publications/dictionaries/cancer-terms/def/narcotic>
22. Medical dictionary by Farlex, <https://medical-dictionary.thefreedictionary.com/psychotropic+substances>
23. Oxford concise medical dictionary, www.oxfordreference.com
24. MedTerms Medical Dictionary A-Z, <https://www.medicinenet.com/infection/definition.htm>
25. Embryo vs. fetus week by week, https://www.medicinenet.com/embryo_vs_fetus_differences_week-by-week/article.htm
26. Britannica:fetus, <https://www.britannica.com/science/fetus>
27. Embryo vs. Fetus: Differences Between Stages Week by Week, https://www.medicinenet.com/embryo_vs_fetus_differences_week-by-week/article.htm
28. Britannica:Abortion, <https://www.britannica.com/science/abortion-pregnancy>
29. Iowa center for Assistive Technology Education and Research:Module 1 - Conceptualizing Disability, https://www.continuetolearn.uiowa.edu/nas1/07c187/Module%201/module_1_p3.html
30. Britannica:Psychotherapy, <https://www.britannica.com/science/psychotherapy>
31. A List of Psychological Disorders, <https://www.verywellmind.com/a-list-of-psychological-disorders-2794776#:~:text=The%20term%20psychological%20disorders%20is,the%20person%20experiencing%20the%20symptoms>
32. A List of Psychological Disorders, <https://www.verywellmind.com/a-list-of-psychological-disorders-2794776#:~:text=The%20term%20psychological%20disorders%20is,the%20person%20experiencing%20the%20symptoms>

33. Types and Symptoms of Common Psychiatric Disorders, <https://www.verywellmind.com/psychiatric-disorder-definition-425317#citation-2>
34. CD-10 Version:2019: (F00-99), <https://icd.who.int/browse10/2019/en#/F00-F09>
35. American Psychological Association: Different approaches to psychotherapy, <https://www.apa.org/topics/psychotherapy/approaches>
36. Food supplements, <https://www.efsa.europa.eu/en/topics/topic/food-supplements#:~:text=Food%20supplements%20are%20concentrated%20sources,%2C%20liquids%20in%20measured%20doses>).
37. Food standart agency: Approved additives and E numbers, <https://www.food.gov.uk/business-guidance/approved-additives-and-e-numbers>
38. Types Of Treatment: Addiction center, <https://www.addictioncenter.com/treatment/>
39. U.S. Reports: Katz v. United States, 389 U.S. 347 (1967)., <https://privacylibrary.ccnlud.org/case/katz-vs-united-states>
40. Tn Courts: Firearm definition, https://www.tncourts.gov/sites/default/files/docs/firearmshandout_1.pdf
41. Table 1: types of firearms ,Updated 7 January 2021, <https://www.gov.uk/government/publications/deactivated-firearms-implementing-regulation-eu-20152403/table-1-types-of-firearms> Gunvault: Types of Ammunition, <https://gunvault.com/types-of-ammunition/>